# УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН АСУУДАЛ

*Л. Батжав*

**АГУУЛГА**

ОРШИЛ

1. УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТАЛААРХИ ГАДААД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА
   - ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УЛС ТӨРИЙН НАМ БҮРТГЭХ ҮЙЛ ЯВЦ
   - ДЭЛХИЙН ОРНУУДЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ТОГТОЛЦОО
   - УЛС ТӨРИЙН НАМГҮЙ ОРНУУДЫН ЖАГСААЛТ
2. МОНГОЛ УЛС ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН БАЙДАЛ
   - МОНГОЛ УЛС ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМД ЭЛСЭХ, ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗЭХ, ГАРАХ, ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРГИЙН ХАРЬЦУУЛАЛТ
   - МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД УЛСЫН БҮРТГЭЛТЭЙ УЛС ТӨРИЙН НАМУУДЫН МЭДЭЭЛЭЛ
3. МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН НАМЫН ХАРЬЯАЛАЛЫН ТАЛААРХИ СУДАЛГАА
4. НАМ ГИШҮҮНЧЛЭЛГҮЙ БАЙХ АСУУДЛААРХИ УЛС ТӨРИЙН ХҮЧИН БОЛОН ИРГЭДИЙН САНАЛ БОДОЛ
   - НАМ ГИШҮҮНЧЛЭЛГҮЙ БАЙХ АСУУДЛААРХИ УЛС ТӨРИЙН ХҮЧНИЙ ГИШҮҮДИЙН САНАЛ БОДОЛ
   - НАМ ГИШҮҮНЧЛЭЛГҮЙ БАЙХ АСУУДЛААРХИ ОЛОН НИЙТ, ИРГЭДИЙН САНАЛ БОДОЛ
5. ДҮГНЭЛТ
6. УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ТУХАЙ ЗАРИМ ХЭРЭГЦЭЭТ ЦАХИМ ХУУДАС, ХАЙХ СЭДЭВ
7. АШИГЛАСАН МАТЕРИАЛ
8. 
9. ХАВСРАЛТ
   - САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС
   - МОНГОЛ УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ УЛС ТӨРИЙН НАМУУДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

* * *

## Оршил

УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс “Улс төрийн намуудын гишүүнчлэлийн байдал” сэдэвт харьцуулсан судалгаа, мэдээлэлийг хийж гүйцэтгэв. Бид улс төрийн намыг ойлгохдоо засгийн эрхийг авахын төлөөх бүлэг хүмүүсийн нэгдэл гэж ойлгодог. Намын тухай энэ ардчилсан бус ойлголтыг 21 зууны дэлхий нийтийн ардчиллын үнэт зүйл болох хүний эрх, эрх чөлөө, иргэний оролцоотой холбож ойлгох цаг нэгэнт болжээ. Учир нь орчин үеийн ардчилал, дэлхий нийтийн хандлагатай мөр зэрэгцэн оршиж буй Монгол Улс өөрийгөө хүмүүнлэг, иргэний, чөлөөт ардчилсан гэж тодорхойлж л байгаа цагт улстөрийн нам ямар байх ёстой, гишүүнчлэлийн ямар бодлого баримталж байгаа вэ, ардчиллыг бэхжүүлэхийн тулд намууд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ, нам хатуу гишүүнчлэлгүй болчихоор парламентаа яаж сонгох вэ, ер нь улс төрийн ямар нөхцөл байдал үүсэх бол, нам гишүүнчлэлгүй болох нь ирээдүйгээ харсан хандлага мөн үү зэрэг асуултад хариулт өгөх, олон улсын жишгийг захиалагчид танилцуулахыг зорьж энэхүү судалгааг хийлээ.

Улстөрийн нам бол хүний эрх, эрх чөлөөг хангахын тулд нийгмийн идэвхитэй, оюунлаг иргэдийн улстөрийн эрх, эрх чөлөөт оролцоонд тулгуурласан “оюуны цөм” болсон байгууллага юм. Нам бол иргэдийн эрх чөлөө, улстөрийн оролцооны илэрхийлэл болж ардчиллыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй, улстөрийн хариуцлагыг төлөвшүүлдэг нийгмийн

болон улстөрийн институт юм. Орчин үеийн намууд хатуу эсвэл сул гишүүнчлэлтэйгээс үл хамааран тухайн үнэт зүйлийг дэмжигч гишүүд болон сонгогчдод хэр хүрч, нээлттэй, хариуцлагатай байгаагаас хамааран сонгуульд ялалт байгуулдаг болсон.

Харин Монгол Улсад намуудын гишүүнчлэлийн хувьд ямар байна вэ? Судлаачид намуудыг хатуу гишүүнчлэлтэй гэж дүгнэдэг. Үнэхээр гишүүн элсүүлэх нь намын гол бодлого мөн эсэхийг судалж, гадаад орнуудаас авч хэрэгжүүлэх болохуйц туршлага бий эсэхийг тодорхойлох үүднээс энэхүү харьцуулсан судалгаа, мэдээлэлийг хийлээ. Ер нь Монгол Улсын хувьд 1990 онд улстөрийн нам төрийн ажлыг удирдах явдал дуусгавар болж байсан ч тухайн үедээ зарим нэг гол зарчмыг орхигдуулсан. Өөрөөр хэлбэл, төрийн албан дахь түшмэд, албан хаагчид зөвхөн нийтийн сонирхолд захирагдаж ажиллах тухай асуудал жинхэнэ утгаараа хуульчлагдаагүй үлдсэн. Энэ асуудлыг хөндөхийг зорилоо.

**Судалгааны хамрах хүрээ:**

Дэлхийн бүх орны улс төрийн намын тогтолцоо, гишүүнчлэл, эрх барьж буй нам, хамгийн сүүлд болж өнгөрсөн сонгуулийн асуудлыг тодорхой хүрээнд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх намуудын дүрмүүдийг нэгбүрчлэн судаллаа.

**Судалгааны зорилго, зорилт:**

Энэхүү судалгааны ажлын зорилго нь улс төрийн намуудын гишүүнчлэлийн асуудлаарх судалгааг дэлхийн бүх орныг хамруулан судлаж, олон улсын чиг хандлагыг захиалагчид мэдээлэх явдал юм. Судалгааны ажлын энэхүү зорилгыг хангах үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлж, шийдвэрлэхийг зорьсон болно. Үүнд:

1. Монгол Улсын улс төрийн намын тухай хуулийг гадаад улсуудын хуультай харьцуулан судлаж, нарийвчлан тодорхойлох,
2. Гадаадын зарим орны улс төрийн намыг бүртгэх үйл явц, дэлхийн улсуудын улс төрийн намуудын тогтолцоо, хамгийн сүүлд явуулсан сонгууль, эрх барьж буй нам зэрэг асуудалд шинжилгээ хийж, судалгааны дүгнэлт хийх,
3. Монгол Улс дахь гишүүнчлэлийн байдал, намд элсэх, гишүүнээс түдгэлзэх, гарах, гишүүний эрх, үүргийг судлах,
4. Монгол Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудын мэдээлэлийг нэгтгэх,
5. Монгол Улсын иргэдийн улс төрийн намын харьяалалын талаархи судалгаа хийж, нам гишүүнчлэлгүй байх асуудлаархи улс төрийн хүчин болон иргэдийн байр суурийг судлаж, нийгмийн санаа бодол, сэтгэл зүйд дүн шинжилгээ хийх.

Захиалагчид болон үргэлжлүүлэн судлах хүмүүст зориулж улс төрийн намуудын тухай зарим хэрэгцээт цахим хуудас, хайх сэдэв, ашигласан материалын жагсаалтыг дэлгэрэнгүйгээр оруулж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх намуудын мөрийн хөтөлбөрийг хавсралтаар оруулав.

## 1. УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТАЛААРХИ ГАДААД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

### • ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УЛС ТӨРИЙН НАМ БҮРТГЭХ ҮЙЛ ЯВЦ

Нэгэнтээ байгуулагдсан улс төрийн намыг хэрхэн яаж бүртгүүлдэг вэ. Нам байгуулж бүртгүүлэхэд юу юу шаарддаг вэ. Энэ үйл ажиллагаа улс орон бүрт нэг мөр байдаг боловч бас өөр өөрийн онцлоготой байх юм. Ер нь бол нам бүртгүүлэх үйл ажиллагааг институтжих (нийгэмжих) гэдэг байна. Нэг ёсондоо хууль эрх зүйн хүрээнд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөж нийгэмд хөл алхаж байна гэсэн үг. Монгол Улсад улс төрийн намыг Дээд шүүхэд бүртгэдэг. Харин Герман, Итали, Франц, Грек, Испани, Португал, Бразил

зэрэг улсад Намын үйл ажиллагааг санхүүжүүлэх тухай хуулийн дагуу, Австри, Швейцарь, Финланд, Японд Сонгуулийн тухай хуулийн хүрээнд, АНУ, Мексикт манайх шиг шүүхийн шийдвэрээр буюу Дээд шүүх нь бүртгэж зөвшөөрөл олгоснор статусыг нь баталгаажуулдаг байна. Энэ бүх үйл ажиллагаа мэдээж тухайн улс бүрийн Үндсэн хуулийн хүрээнд явагддаг.

**Бүртгэл:**

Намыг бүртгэхдээ заавал буюу албан ёсоор, эсвэл сайн дурын буюу чөлөөт байдлаар "шийддэг" байна. Жишээ нь, Их Британи болон Шинэ Зеландад улс төрийн намыг заавал бүртгэдэггүй. Үүнийг иргэдийн хувийн үйл хэрэг хэмээн ойлгож, чөлөөт нэгдлийн үндсэн дээр хэрэгжиг, нам өөрийнхөө дүр төрхийг тунхаглаж түүгээрээ оршин тогтног гэж үздэг байна. Гэхдээ чөлөөт байдлыг эрхэмлэсэн энэ либериал үзэл эдүгээ цагт хуучин уламжлалтайгаа хамт хумигдсаар байна.

Үүний оронд улс төрийн намыг заавал бүртгэж байх эрх зүйн акт бүхий тогтолцоо ноёлох болжээ. Энэ нь дотроо бас янз бүр. Испани, Итали, Францад намыг Дотоод хэргийн яам нь, Бельги, Нидерландад (Голланд) Хууль зүйн яам нь, АНУ-ын Миссури мужид мужийн Төрийн нарийн бичгийн газар бүртгэдэг бол Португали, Бразилд манайх шиг шүүхийн шийдвэрээр Дээд шүүх нь бүртгэдэг байна. Энэтхэг, Мексик, Швейцарьт сонгууль явуулахын тулд байгуулагдсан байгууллагууд бүртгэдэг байна. Харин намыг татан буулгахад Герман, Франц, Португалид шүүхийн шийдвэрээр, Унгарт Үндсэн хуулийн хүрээнд, Германд Хууль зүйн яам, Швейцарьт тусгай бүртгэлээс хасагдсан нөхцөлд тухайн улс төрийн намын статусыг цуцалж хүчингүй болгодог байна.

**Шаардлага:**

Никарагуа Улсыг эс тооцвол дэлхийн ихэнх улс оронд улс төрийн нам байгуулахад урьдчилсан зөвшөөрөл аваад байдаггүй, шаарддаг ч үгүй байна. Хууль ёсны зөвшөөрөл бүхий статус авахын тулд албан ёсоор бичсэн материал шаардлагатай нь мэдээж. Энд тухайн намын нэр, бэлэг тэмдэг багтдаг. Ингэхдээ тэдгээр нь тухайн орны төр, шашны бэлэгдэлтэй адил бус байхыг урьдчилан сануулдаг байна.

Нам байгуулж, бүртгүүлэхэд аль ч улс оронд нэг голлодог зүйл нь тухайн намын гишүүд болон дэмжигчдийн тоо байдаг. Ихэнх улс оронд үүнийг харгалзан бүртгэдэг. Үүгээр үзэх юм бол Швейцарьт сонгогчдын 1,5 мянгаас доошгүй гарын үсэг цуглуулах шаардлагатай байдаг бол Португалид 5 мянган сонгогчийг төлөөлсөн байх үүрэгтэй. Эдгээр нь тухайн улсын сонгогчдын буюу сонгуульд оролцож санал өгөх насны нийт хүмүүсийн тоотой харьцуулсан хувь юм. Тухайлал, АНУ-ын 20-иод муж улсын хууль тогтоох байгууллага намуудаас сонгогчдын ерөнхий тооны хувиар илэрхийлсэн тодорхой тооны гарын үсгийг шаарддаг байна. Жишээ нь, Өмнөд Дакотад энэ тоо 10 хувь байдаг бол Миннесотад 5 хувь байдаг. Ингэхдээ муж улсын түвшинд тухайн намын гишүүн ямар нэг албан тушаалтан сүүлийн сонгуульд нэр дэвшиж ялсан, эсвэл бүх нэр дэвшигчдийн төлөө санал өгсөн хүмүүсийн хувиас хамааран бүртгэдэг байна. Эдгээр нь сонгогчдын төлөөлөл болохоос биш манайх шиг хатуу гишүүнчлэлтэй улсынх шиг намын гишүүдийн тоог хэлж байгаа юм биш.

Учир нь барууны орнуудад намын гишүүнчлэл гэж бараг байдаггүй, зөвхөн дэмжигчид байдаг. Тиймээс тэнд намын гишүүдийн тоог харгалздаггүй. Харин яс гишүүнчлэлтэй орнуудын хувьд Унгарт нам бүртгүүлэхэд гишүүн-үүсгэн байгуулагчдын тоо 1000 байх ёстой байдаг аж. Мексикт энэ тоо 65 мянгаар хэмжигддэг байна.

Энэтхэгт бүр хэцүү, шат дараалсан том шаардлагатай. Энд нам бүртгүүлэхэд эхлээд бүс нутгийн статус авдаг. Дараа нь нийт үндэсний хэмжээнд зөвшөөрөгдөхөд нийт сонгогчдын 4 хувийн саналыг авсан байх ёстой. Ингэхдээ 5-аас доошгүй жил улс төрийн үйл ажиллагаа

явуулсан байх гэх мэт хэрэгтэй. Ингэж байж тухайн нам Энэтхэгийн 4 муж, бүс нутгийн бүртгэлтэй болж байж нийт Энэтхэгийн хэмжээнд намын статусаа сая нэг юм төвөггүй авдаг байна. Герман, Португал, Бразил зэрэг оронд нам бүртгүүлэхэд маш их баримт материал гаргаж өгөх ёстой. Үүнд намын дүрэм, мөрийн хөтөлбөр, өргөдөл, санхүүгийн болон хөрөнгийн зарцуулалт, намын бүрэлдэхүүн зэрэг ордог байна.

- **ДЭЛХИЙН ОРНУУДЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ТОГТОЛЦОО**

| Улс орнууд | Улстөрийн намын тогтолцлл | | | |
|---|---|---|---|---|
| | Олон намын | Хоёр намын | Нэг нам зонхилсон | Нэг намын |
| Abkhazia | • | | | |
| Afghanistan[1] | • | | | |
| Albania | • | | | |
| Algeria | • | | | |
| Andorra | • | | | |
| Angola | | | • | |
| Anguilla | • | | | |
| Antigua and Barbuda | | • | | |
| Argentina | • | | | |
| Armenia | • | | | |
| Aruba | | • | | |
| Australia | • | | | |
| Austria | • | | | |
| Azerbaijan | | | • | |
| Bahrain | | | •[2] | |
| Bangladesh | • | | | |
| Barbados | | • | | |
| Belarus | | | • | |
| Belgium | • | | | |
| Belize | | • | | |
| Benin | • | | | |
| Bermuda | | • | | |
| Bhutan | | • | | |
| Bolivia | • | | | |
| Bosnia and Herzegovina | • | | | |
| Botswana | | | • | |
| Brazil | • | | | |
| British Virgin Islands | | • | | |
| Bulgaria | • | | | |
| Burkina Faso | | | • | |
| Burundi | • | | | |
| Cambodia | | | • | |
| Cameroon | | | • | |
| Canada | • | | | |
| Cape Verde | | • | | |
| Cayman Islands | | • | | |
| Central African Republic | • | | | |
| Chad | | | • | |
| Chile | • | | | |
| China | | | | • |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Colombia | • | | | |
| Comoros | | •[3] | | |
| Congo (Brazzaville) | | | • | |
| Congo (Kinshasa) | • | | | |
| Cook Islands | | | • | |
| Costa Rica | • | | | |
| Сфте d'Ivoire | | • | | |
| Croatia | • | | | |
| Cuba | | | | • |
| Cyprus | • | | | |
| Czech Republic | • | | | |
| Denmark | • | | | |
| Djibouti | | | • | |
| Dominica | | • | | |
| Dominican Republic | • | | | |
| East Timor | • | | | |
| Ecuador | • | | | |
| Egypt | | | • | |
| El Salvador | • | | | |
| Equatorial Guinea | | | • | |
| Eritrea | | | | • |
| Estonia | • | | | |
| Ethiopia | • | | | |
| European Union | • | | | |
| Falkland Islands | | | | |
| Faroe Islands | • | | | |
| Fiji | | • | | |
| Finland | • | | | |
| France | • | | | |
| French Polynesia | | • | | |
| Gabon | | | • | |
| Gambia | | | • | |
| Georgia | | | • | |
| Germany | • | | | |
| Ghana | • | | | |
| Gibraltar | • | | | |
| Greece | | • | | |
| Greenland | • | | | |
| Grenada | | • | | |
| Guam | | • | | |
| Guatemala | • | | | |
| Guinea | | | • | |
| Guinea-Bissau | • | | | |
| Guyana | | • | | |
| Haiti | • | | | |
| Honduras | | • | | |
| Hong Kong | • | | | |
| Hungary | • | | | |
| Iceland | • | | | |
| India | • | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Indonesia | • | | | |
| Iran | •[5] | | | |
| Iraq | • | | | |
| Ireland | • | | | |
| Israel | • | | | |
| Italy | • | | | |
| Jamaica | | • | | |
| Japan | | • | | |
| Jersey | •[6] | | | |
| Jordan | •[7] | | | |
| Kazakhstan | | | • | |
| Kenya | • | | | |
| Kiribati | • | | | |
| Kyrgyzstan | • | | | |
| Kosovo | • | | | |
| Laos | | | | • |
| Latvia | • | | | |
| Lebanon | • | | | |
| Lesotho | | | • | |
| Liberia | • | | | |
| Liechtenstein | | • | | |
| Lithuania | • | | | |
| Luxembourg | • | | | |
| Macau | • | | | |
| Macedonia | • | | | |
| Madagascar | • | | | |
| Malawi | • | | | |
| Malaysia | | | • | |
| Maldives | • | | | |
| Mali | • | | | |
| Malta | | • | | |
| Marshall Islands | | • | | |
| Mauritania | •[8] | | | |
| Mauritius | • | | | |
| Mayotte | • | | | |
| Mexico | • | | | |
| Moldova | • | | | |
| Monaco | | | • | |
| Mongolia | • | | | |
| Montenegro | • | | | |
| Montserrat | | • | | |
| Morocco | • | | | |
| Mozambique | | • | | |
| Nagorno-Karabakh | • | | | |
| Namibia | | | • | |
| Nauru | | | | |
| Nepal | • | | | |
| Netherlands | • | | | |
| New Caledonia | • | | | |
| New Zealand | • | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Nicaragua | • | | | |
| Niger | • | | | |
| Nigeria | • | | | |
| Niue | | | | |
| North Korea | | | | • |
| Northern Marianas | | • | | |
| Norway | • | | | |
| Pakistan | • | | | |
| Palestinian National Authority | | • | | |
| Panama | • | | | |
| Papua New Guinea | • | | | |
| Paraguay | • | | | |
| Peru | • | | | |
| Philippines | • | | | |
| Poland | • | | | |
| Portugal | • | | | |
| Puerto Rico | • | | | |
| Romania | • | | | |
| Russia | • | | | |
| Rwanda | | | • | |
| Saint Kitts and Nevis | | • | | |
| Saint Lucia | | • | | |
| Saint Pierre and Miquelon | • | | | |
| Saint Vincent and the Grenadines | | • | | |
| Samoa | | | • | |
| San Marino | • | | | |
| Sro Tomй and Pгнncipe | • | | | |
| Senegal | • | | | |
| Serbia | • | | | |
| Seychelles | | • | | |
| Sierra Leone | • | | | |
| Singapore | | | • | |
| Slovakia | • | | | |
| Slovenia | • | | | |
| Solomon Islands | • | | | |
| South Africa | | | • | |
| South Ossetia | • | | | |
| South Korea | • | | | |
| Spain | • | | | |
| Sri Lanka | | • | | |
| Sudan | | | • | |
| Suriname | • | | | |
| Sweden | • | | | |
| Switzerland | • | | | |
| Syria | | | | • |
| Taiwan (Republic of China) | • | | | |
| Tajikistan | | | • | |
| Tanzania | | | • | |
| Thailand | • | | | |
| Togo | | | • | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Tonga | • | | | |
| Transnistria | • | | | |
| Trinidad and Tobago | | • | | |
| Tunisia | | | • | |
| Turkey | • | | | |
| Turkmenistan | | | | • |
| Turks and Caicos | | • | | |
| Uganda | | | • | |
| Ukraine | • | | | |
| United Kingdom | • | | | |
| United States | | • | | |
| Uruguay | • | | | |
| Uzbekistan | | | • | |
| Vanuatu | • | | | |
| Venezuela | | | • | |
| Vietnam | | | | • |
| Virgin Islands of the United States | • | | | |
| Wallis and Futuna | • | | | |
| Western Sahara | | | | • |
| Yemen | | | • | |
| Zambia | • | | | |
| Zimbabwe | | • | | |

**УЛС ТӨРИЙН НАМГҮЙ ОРНУУДЫН ЖАГСААЛТ**

- Bahrain
- Bhutan
- Christmas Island
- Cocos Islands
- Falkland Islands
- Federated States of Micronesia
- Guernsey
- Kuwait
- Libya
- Maldives
- Norfolk Island
- Oman
- Palau
- Pitcairn Islands
- Qatar
- Saint Helena
- Saudi Arabia
- Swaziland
- Tokelau
- Tonga
- Tuvalu
- United Arab Emirates

## 2. МОНГОЛ УЛС ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН БАЙДАЛ

Бид улс төрийн намыг ойлгохдоо засгийн эрхийг авахын төлөөх бүлэг хүмүүсийн нэгдэл гэж ойлгодог. Намын тухай энэ ардчилсан бус ойлголтыг 21 зууны дэлхий нийтийн ардчиллын үнэт зүйл болох хүний эрх, эрх чөлөө, иргэний оролцоотой холбож ойлгох цаг нэгэнт болжээ. Учир нь орчин үеийн ардчилал, дэлхий нийтийн хандлагатай мөр зэрэгцэн оршиж буй Монгол Улс өөрийгөө хүмүүнлэг, иргэний, чөлөөт ардчилсан гэж тодорхойлж л байгаа цагт улстөрийн нам ямар байх ёстой, гишүүнчлэлийн ямар бодлого баримталж байгаа вэ, ардчиллыг бэхжүүлэхийн тулд намууд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ зэрэг асуулт урган гарч ирнэ.

Улстөрийн нам бол хүний эрх, эрх чөлөөг хангахын тулд нийгмийн идэвхитэй, оюунлаг иргэдийн улстөрийн эрх, эрх чөлөөт оролцоонд тулгуурласан “оюуны цөм” болсон байгууллага юм. Нам бол иргэдийн эрх чөлөө, улстөрийн оролцооны илэрхийлэл болж ардчиллыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй, улстөрийн хариуцлагыг төлөвшүүлдэг нийгмийн болон улстөрийн институт юм. Орчин үеийн намууд хатуу эсвэл сул гишүүнчлэлтэйгээс үл хамааран тухайн үнэт зүйлийг дэмжигч гишүүд болон сонгогчдод хэр хүрч, нээлттэй, хариуцлагатай байгаагаас хамааран сонгуульд ялалт байгуулдаг болсон.

Харин манай намууд ямар байна вэ? Судлаачид намуудыг хатуу гишүүнчлэлтэй гэж дүгнэдэг. Үнэхээр гишүүн элсүүлэх нь намын гол бодлого болж, намын гишүүн мөн болохыг баталсан батламж, үнэмлэхийг өнгөрсөн 20 жилийн турш цацжээ. Гэвч гишүүдээ хүндэтгэдэг, гишүүндээ чиглэсэн бодлого хэрэгжүүлдэг, тэдний улстөрийн боловсролд анхаардаг, гишүүдийн эрх, үүргийг хангадаг, хариуцлагатай намууд олон нийтийн судалгаагаар алга байна. Үндсэн хууль болон бусад хууль /намын тухай хууль/-ндаа улстөрийн намууд гишүүдийн эрх, эрх чөлөөг хэрхэн хангах, шийдвэр гаргах төвшинд хэрхэн оролцуулах, намууд ямар үүрэгтэй байх, мөн гишүүдийн үүрэг, хариуцлагыг огт тодорхойлоогүй байна. Энэ нь өнөөдрийн “гишүүдтэй атлаа гишүүнгүй намууд”-уудыг өлгийдсөн. Нэг үгээр хэлбэл намтай холбогдох эрх зүйн орчинд буй нэг цоорхой бол оролцоот гишүүнчлэлийн бодлого бөгөөд хаа хаанаа гишүүдийн оролцоог дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлээгүй байна.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд олон намууд үүсэж, улстөрийн тавцанд өрсөлдөж байгаа ч үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт нь бүхэлдээ төлөвшиж /ардчилагдаж/ чадаагүй л байна. Ардчиллын үлгэр жишээ болдог Баруун Европын болон Хойд Америкийн орнуудад намд гишүүнээр элсэх, шийдвэр гаргах төвшинд оролцох, иргэний эрхээ эдэлж, үүргээ хүлээх нь хэдийнэ соёл болоод тогтсон. Жишээ нь ХБНГУ-ын “Улстөрийн намын тухай хууль”-ийн 10-р зүйлд гишүүдийн эрхийг нарийвчлан заасан байна. Мөн бидэнтэй зэрэг ардчилагдсан гэх Зүүн Европын Унгар, Словак улсууд намын жирийн гишүүдийн оролцоог идэхижүүлэхэд амжилт гаргаж байна.

Орчин үед судлаачид улстөрийн намын дотоод ардчилал гэдэгт төрийн албанд буй өөрсдийн төлөөлөгчид болон лидерүүдийн үйл байдал, намын шийдвэрүүдийг удирдах, хянах гишүүдийн чадвар, хэр хэмжээ, тэдгээрийн идэвхитэй оролцоогоор тодорхойлогдоно гэж үзэж байна. Энэ бол намын ардчиллыг тодорхойлох ганц шалгуур бөгөөд иргэдийн улстөрийн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахын тулд гишүүд, дэмжигчдэд хүрч үйлчилж чадсан нам ардчилагдана, мөн сонгуульд ялалт байгуулна үздэг.

Улстөрийн намуудын засгийн эрх барих өрсөлдөөн нь улс болгонд хүний үндсэн эрхийг зөвшөөрөх, шударга, тэгш, өрсөлдөх боломжийг зорилготой. Сонгуулийн ардчилал нь нийгмийн салбаруудад, нэр дэвшигчийн бүлгүүдэд, төлөөлөх бодлого болон альтернатив улстөрийн намуудын хоорондын нээлттэй, шударга өрсөлдөөний зарчим дээр үндэслэдэг бөгөөд энэ нь санал хураах замаар шийдвэрлэгддэг. Хэрэв намын байгууллага үүнийг буруугаар ашиглавал эрх баригчидттай хариуцлага тооцох, сонирхлоо нэгтгэх, илэрхийлэх

иргэдийн чадвар хязгаарлагддаг. Манай намуудын гишүүдэд ийм оролцоо байхгүй байна. Энэ нь хэд хэдэн учир шалтгаанаар тайлбарлагдаж болох юм.

1. Бидний нүүдэлчин амьдрал, ардчиллын үнэт зүйлсийг тунхаглалын төдий лоозогнодог коммунист уламжлал, бусдад найддаг ил итгэх, өөрсдөө оролцохгүй атлаа бусдын оролцоог хязгаарлах сэтгэлгээтэй холбоотой. Нөгөөтэйгүүр нам хэмээх байгууллагыг бизнесийн нүдээр хардаг, намууд нь бас үнэт зүйл, итгэл үнэмшил ямар байх нь чухал биш зөвхөн хэн илүү мөнгө өгч байгаагаар намд эзлэх гишүүдийн байр суурь нь тодорхойлогддог болжээ.
2. Намууд хэт гишүүнчлэлээр уралдах болсон. Ардчилал өндөр хөгжсөн орнуудад нийт сонгогчдийн дунд намын гишүүний эзлэх хувь ердөө 10-15 % нь л байдаг. Харин манайд намуудын сонгуулийн үед зарладаг гишүүдийн тоог нэмэхэд нийт сонгогчдын тоотой дүйж магадгүй болжээ. Улстөрийн намын хувьд бол гишүүд нь үнэт капитал болж, сонгогчид болон дэмжигчдэд цаг үргэлж үлгэр дуурайлал болж байх ёстой. Хэт их гишүүнчлэлийн сул тал нь одоо та бидний өдөр тутмын амьдралд үүсээд байгаа намчирхах өвчин юм 1990 оноос намд элсэх нь сайн сайхан амьдралын баталгаа болж, маш өндөр шалгуураар элсэж байсан нь “намын гишүүн болох” өвчнөөр өвчүүлжээ. Энэ өвчин ардчилалд шилжсэнээр эдгэрээгүй бөгөөд харин ч улам сэдэрч олон намууд байгуулагдаж, олон ч иргэд гишүүнээр элсэв._
3. Намын шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн болон залуучуудын оролцоо үгүйлэгдэж байна. Намуудын хувьд эмэгтэйчүүд болон залуучууд, ахмадуудынхаа сонирхлыг хадгалж байхын тул дэргэдээ бие даасан хуулийн этгээдээр олон нийтийн байгууллага байгуулдаг. Гэвч эдгээр байгууллага нь гишүүдийн сонирхлын төлөөлж чадахгүй, зөвхөн нам дахь гишүүдийг тоог хадгалах, өсгөх “захиалгат” үүрэгтэйгээр ажиллаж байна. Түүнээс биш гишүүдийн эрх ашгийг хамгалаалах, оролцоог нэмэгдүүлэхэд төдийлэн анхаардаггүй нь нууц биш.
4. Харизматик лидерүүдийг хэт тойрон хүрээлсэн зохион байгуулалттай байна. Өнөөгийн бүх нам цөөн хэдэн улстөрчдийн хийдэг ажил болсон бөгөөд түүнийг тойрон хүрээлэгчдийн эрх ашигт бүхий л намын бодлого чиглэж байна. Энэ хүрээнд орж чадахгүй л бол та улстөрд маш их эрсдлийг өөртөө авчрах бичигдээгүй хууль үйлчилж байна. Намын гишүүд, дэмжигч, сонгогчдын хувьд шинээр лидер төрөх боломжийг сэтгэлгээ, зан үйлээрээ өөрсдөө ч мэдэхгүй хааж байна. Учир нь тэд “хэн ч гарсан ялгаагүй адилхан л идэж ууна”, “чамтай чамгүй болно”, “төрийн төлөө огтоно боож үхэх нь” зэргээр өөрсдийн оролцоог хязгаарладаг.

- УЛС ТӨРИЙН НАМД ЭЛСЭХ, ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗЭХ, ГАРАХ, ГИШҮҮНИЙ ЭРХ ҮҮРГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

| | ГИШҮҮНЭЭР ЭЛСАХ | ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ | ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗЭХ | ГИШҮҮНЭЭС ГАРАХ |
|---|---|---|---|---|
| **МОНГОЛ АРДЫН НАМ** | 3 дугаар зүйл. Монгол Ардын Намд гишүүнээр элсэх<br>3.1. Монгол Ардын Намын хичээн эрмэлзэх зүйл /мөрийн хөтөлбөр/, дүрмийг зөвшөөрч, үйл ажиллагааг нь дэмжихээ илэрхийлсэн Монгол Улсын 18 нас хүрсэн иргэн Монгол Ардын Намд гишүүнээр элсэж болно. Намын гишүүнээр элсэж байгаа иргэн нь Монгол Ардын Намын хичээн эрмэлзэх зүйл /мөрийн хөтөлбөр/, дүрмийг судалсан байвал зохино.<br>3.2. Намд гишүүнээр элсэхээ илэрхийлсэн иргэний хүсэлтийг оршин суугаа газарт нь үйл ажиллагаа явуулдаг намын анхан шатны байгууллага /НАШБ/ хүлээн авч шийдвэрлэн намын бат илэрхийлэл олгож бүртгэнэ. Монгол Ардын Намд элсэх өргөдлийг бичгээр гаргана. | 4 дүгээр зүйл. Монгол Ардын Намын гишүүний эрх, үүрэг<br>4.1. Гишүүн дор дурдсан эрх эдлэнэ:<br>4.1.1. Намын үзэл баримтлал, бодлого боловсруулах, хэлэлцэхэд болон намаас явуулж буй үйл ажиллагаанд оролцох;<br>4.1.2. намын удирдах байгууллагад нэр дэвшүүлэх, өөрийн нэрийг дэвшүүлэх, сонгох, сонгогдох;<br>4.1.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын болон орон нутгийн сонгуульд намаас нэр дэвших хүмүүсийн талаар намын байгууллагад саналаа тавих;<br>4.1.4. улс орны болон намын дотоод амьдралын асуудлаар санал тавьж хариу авах, шүүмжлэх, мэдээлэл өгөхийг шаардах;<br>4.1.5. намын байгууллагаас өөрийнх нь тухай хэлэлцэхэд биечлэн оролцох;<br>4.1.6. үзэл бодол, гишүүнчлэлийн хувьд намын өмгөөлөл, ивээл баттах;<br>4.1.7.намд туслах зорилгоор гишүүд бүлгэм, клубт нэгдэн ажиллаж болно;<br>4.1.8. гишүүдийн төлсөн татвар, өргөсөн хандив, намын сан хөмрөгийн зарцуулалтын санхүүгийн тайланг сонсох.<br>4.2. Намын гишүүн дор дурдсан үүрэг хүлээнэ:<br>4.2.1. намын дүрмийг чанд сахин биелүүлэх;<br>4.2.2. гишүүн байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн анхан шатны байгууллагад харьяалагдан намын ажилд идэвхтэй оролцон намын мөрийн хөтөлбөр, бодлогыг сурталчлах, хэрэгжүүлэх;<br>4.2.3. намын эгнээ, дэмжигчдийн хүрээг өргөтгөхөд тус дөхөм үзүүлэх;<br>4.2.4. төрийн болон орон нутгийн аливаа сонгуульд Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийг сурталчлан дэмжих;<br>4.2.5. намын эв нэгдлийг хамгаалах, намын нэр хүндийг гутаасан аливаа үйлдэл гаргахгүй байх;<br>4.2.6. намын эрх ашигт үл нийцэх улс төрийн үйл ажиллагааг шүүмжлэн няцаах;<br>4.2.7. гишүүний татвар, хураамжийг тогтоосон хугацаанд тогтмол төлөх, хандив өргөх, намын хэвлэл захиалах зэргээр намын сан, хөмрөгийг арвижуулахад идэвхтэй оролцох;<br>4.2.8. намын нэрийн өмнөөс сонгогдсож, томилогдсон албан тушаалтан бүр хуулийг чандлан сахиж ашиг сонирхлын аливаа явцуу бүлэглэлийн нөлөөнд автахгүй байх;<br>4.2.9. намын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх.<br>4.3. Монгол Ардын Намын гишүүн улс төрийн өөр намын гишүүн байхыг хориглоно.<br>4.4. Энэхүү дүрмийн 4.2.5, 4.2.8, 4.2.9-ийг зөрчсөн гишүүнд улс төрийн дараахь дэмжлэг үзүүлэхээс тодорхой хугацаагаар татгалзана:<br>4.4.1. намаас санал болгож сонгогдож, томилогддог аливаа албан тушаалд нэр дэвшүүлэх;<br>4.4.2. хуульд өөрөөр заагаагүй бол одоо ажиллаж байгаа албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах;<br>4.4.3. намын боловсон хүчний нөөцөд бүртгэх.<br>4.5. 4.5. Энэхүү дүрмийн 4.4-т заасан хариуцлагыг тооцохдоо намын Удирдах зөвлөл болон тухайн гишүүнийг хүний нөөцдөө бүртгэсэн намын байгууллагын тэргүүлэгчид нь намын хяналтын байгууллагын дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Гаргасан шийдвэрийг тухайн гишүүнд өөрт нь болон анхан шатны байгууллагад нь мэдэгдэнэ. | 5 дугаар зүйл. Монгол Ардын Намын гишүүнээс түдгэлзэх<br>5.1. Намын гишүүн хууль тогтоомжид заасан тохиолдолд Монгол Ардын Намын гишүүнээс түдгэлзэх бөгөөд энэ тухайгаа НАШБ-д бичгээр мэдэшдэж бүртгүүлнэ.<br>5.2. Түдгэлзэх үндэслэл арилсан бол НАШБ-д хүсэлтээ гаргаж гишүүнчлэлээ сэргээнэ. Намаас түдгэлзсэн нь намын гишүүн байсан нийт хугацаанаас хасагдахгүй. | 6.1. Монгол Ардын Намын гишүүн өөрийн хүсэлтээр намын гишүүнээс гарч болно.<br>6.2. Монгол Ардын Намын гишүүнээс гарч байгаа тухайгаа бичгээр илэрхийлж харьяалагдах намын үүр, анхан шатны хороонд мэдэгдэж бүртгэлээс хасуулан, Монгол Ардын Намын гишүүний бат илэрхийлэхээ эргүлэн өгнө.<br>6.3. Энэ дүрмийн 6.2-т заасан шаардлагыг биелүүлээгүй бол намын гишүүнээс гараагүйд тооцно.<br>6.4. Намын гишүүн нас барсан бол түүний үр хүүхдийн хүсэлтээр намын бат илэрхиллийг дурсган хадгалуулж болно. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **АРДЧИЛСАН НАМ** | 3.1. Гишүүн<br>3.1.1. АН-ын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг сайн дурааараа хүлээн зөвшөөрч байгаа Монгол Улсын 18 нас хүрсэн иргэн намд гишүүнээр элсэж болно.<br>3.1.2. Гишүүн нь байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн анхан шатны байгууллагад бүртгэлтэй, үнэмлэхтэй байна.<br>3.1.3. Намд гишүүн элсэх, гишүүдийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг журмаар зохицуулна.<br>3.1.4. Гишүүний улс төрийн албан тушаалд нэр дэвших, сонгох, сонгогдох, томилогдох үйл ажиллагааг журмаар зохицуулна.<br>3.1.5. Гишүүний хариуцлагыг тогтоосон журмын дагуу зохицуулна. | 3.2. Гишүүний эрх<br>3.2.1. Намын боловсон хүчний хувьд намын эрх бүхий байгууллагын дэмжлэгээр улс төрийн албан тушаалд нэр дэвших, сонгох, сонгогдох, томилогдох;<br>3.2.2. Намын бодлого, үйл ажиллагаа, санхүүжилттэй холбоотой мэдээлэл авах;<br>3.2.3. Намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, бодлого боловсруулах, хэлэлцэхэд болон намаас явуулж буй үйл ажиллагаанд оролцох;<br>3.2.4. Намын байгууллагаас өөрийнх нь тухай хэлэлцэхэд биечлэн оролцохыг шаардах;<br>3.2.5. Намын бүх шатны байгууллагын сонгуульт албан тушаалд нэрээ дэвшүүлж сонгогдсон гишүүнийг сонгуульт гишүүн гэнэ. Сонгуульт гишүүний эрх үүрэг, үйл ажиллагааны зарчмыг журмаар зохицуулах;<br>3.2.6. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, намын Үндсэн Дүрэм /ҮД/ болон бусад журамд харшлаагүй тохиолдолд үзэл бодол, нэр төрийн хувьд намын өмгөөлөл, ивээлд багтах;<br>3.2.7. Гадаадад амьдарч байгаа намын гишүүд, дэмжигчид АН-ыг дэмжих зорилгоор үүсгэл санаачлагын байгууллагад нэгдэж үйл ажиллагаа явуулах.<br>3.3. Гишүүний үүрэг<br>3.3.1. Намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэх, Үндсэн дүрэм болон түүнд нийцүүлэн гаргасан бусад журам, шийдвэрийг даган мөрдөх;<br>3.3.2. Намын эгнээ, дэмжигчдийн хүрээг өргөтгөх, намын байгууллагыг бэхжүүлэхэд идэвх санаачлага гаргах;<br>3.3.3. Төрийн сонгуульд намаас болон бусад намтай байгуулсан Эвслээс нэр дэвшигчтэй өрсөлдөн бие даан нэр дэвшихгүй байх;<br>3.3.4. Намаас нэр дэвшигчдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, нэр дэвшигч болон АН-ын мөрийн хөтөлбөрийг сурталчлах;<br>3.3.5. Намын нэр хүнд, эв нэгдлийг хамгаалах, намын эрх ашигт үл нийцэх аливаа үйл ажиллагааг дэмжихгүй байх;<br>3.3.6. Намын дотоод асуудлаар олон нийтэд хандаж намын нэр хүнд, эв нэгдэл, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх үйлдэл хийхгүй байх;<br>3.3.7. Журмаар тогтоосон хэмжээний татварыг хугацаанд нь төлөх. | 3.4. Гишүүнээс түдгэлзэх, чөлөөлөгдөх<br>3.4.1. Намын гишүүн хууль тогтоомжид заасан үндэслэлээр гишүүнээс түдгэлзэх бөгөөд энэ тухайгаа харьяалах шатны намд албан журмаар мэдэгдэж бүртгүүлнэ.<br>3.4.2. Хуулийн үйлчлэл дуусан бол гишүүнчлэл нь сэргэнэ.<br>3.4.3. Гишүүн намаас чөлөөлөгдөх хүсэлтээ харьяалагдах намын байгууллагадаа мэдүүлснээс хойш 30 хоногийн дотор гишүүнийг бүх шатны намын бүртгэлээс хасуулахыг тухайн шатны нам хариуцна.<br>3.4.4. Намын гишүүн нь намаас гарах хүсэлтийнхээ хамт гишүүний үнэмлэхээ буцааж өгнө.<br>3.4.5. Хэрэв дээрх заалт 3.4.3 –д заасан хугацаанд хэрэгжээгүй бол гишүүнээс чөлөөлөгдсөнд тооцно. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **ҮНДЭСНИЙ ШИНЭ НАМ** | 2.1. ҮШН-ын мөрийн хөтөлбөр, дүрмийг зөвшөөрч, үйл ажиллагааг нь дэмжихээ илэрхийлсэн Монгол Улсын18 нас хүрсэн иргэн нь өөр Улс төрийн намын гишүүн бус аваас үндэс угсаа, хүйс, эрхэлсэн ажил, албан тушаал ялгаварлахгүйгээр тус намд гишүүнээр элсэж болно. | 2.2. Намд элсэх хүсэлтэй гишүүнийг анхан шатны байгууллага нь элсүүлэн бүртгэж авна. Тус намын гишүүн дараах эрх, үүрэгтэй байна.<br>2.3. Намынхаа харьяалагдах шатны байгууллагаар дамжиж Намын дотоод сонгуульд нэр дэвших, сонгох сонгогдох.<br>2.4. Намын боловсон хүчний хувьд намын эрх барих бүхий байгууллагын дэмжлэгээр улс төрийн албан тушаалд сонгогдох, томилогдох.<br>2.5. Үзэл бодол, нэр төр, ёс зүйн хувьд намын өмгөөлөл, ивээлд багтах.<br>2.6. Өөрийн намын сонгуульд нэр дэвшигчдэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх.<br>2.7. Намын хөтөлбөр дүрэм, түүнд нийцүүлэн гаргасан аливаа шийдвэр, журмыг ёсчлон биелүүлэх.<br>2.8. Сонгуульт гишүүн Бүгд хурал болон Удирдах зөвлөөөс гаргасан тусгай журмаар тогтоосон хэмжээний татварыг төлбөл зохих хугацаанд нь төлөх.<br>2.9. Намын эрх ашигт үл нийцэх улс төрийн аливаа үйл ажиллагааг дэмжихгүй байх, намын нэр хүнд, эв нэгдлийг хамгаалах. | 3.1. Намын гишүүн хууль тогтоомжид заасан нөхцөлөөр ҮШН-ын гишүүнээс түдгэлзэх бөгөөд энэ тухайгаа өөрийн харьяалагдах анхан шатны намын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.<br>3.2. Түдгэлзэх үндэс арилсан бол харьяалагдах анхан шатны намын байгууллагад хүсэлтээ бичгээр гаргаж гишүүнчлэлээ сэргээнэ. | 4.1. Гишүүн намаас чөлөөлөгдөх хүсэлтээ харьяаллын дагуу аль нэг шатны намд бичгээр ирүүлснээр намаас чөлөөлөгдөнө. |
| **ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМ** | Нэг. Намын гишүүн<br>1.Монгол Улсын хуулийн насанд хүрсэн иргэн хэн боловч өөрийн намын харьяалалгүй бол өөрийгөө Хөгжлийн Хөтөлбөр намын гишүүн хэмээн албан ёсоор тооцож болно.<br>2.Хөгжлийн Хөтөлбөр нам нь зөвхөн хуулийн хүрээнд гишүүнчлэл үүсгэх бөгөөд үйл ажиллагааны шинж нь гишүүнчлэлгүй байхаар томъёологдоно. Энэ нь үзэл санаа хөтөлбөр зорилт үйл ажиллагаагараа нийгмийн дэмжлэг авах хэлбэр буюу нээлттэй гишүүнчлэлюм.<br>3.Хөгжлийн Хөтөлбөр Намд гишүүнчлэгдсэн иргэд нь Улс төрийн намын тухай хуульд зааснаар өөр намын гишүүн байж үл болно.<br>4.Хөгжлийн хөтөлбөр намын аливаа үйл ажиллагаанд өөр намын бус сонирхсон этгээд хэн боловч оролцох эрхтэй. | 5. Оролцогч этгээдийн эрх үүрэг нь тухайн шийдвэрлэх асуудлаар намын холбогдох байгууллагаас гаргасан түр журмаар зохицуулагдаж явна.<br>6. Энэхүү журмын үндсэн мөрдлөгийг ерөнхий чиглэл тус бүрээр нь намын Төв байгууллага тусгайлан батлах бөгөөд холбогдох асуудлаар нам, сонирхогч этгээдийг харилцааг үндсэн мөрдлөгт нийцүүлэн гаргасан журмаар зохицуулж явна. Журам нь тухайн асуудлыг хэлэлцэж дуусгавар болтол хүчинтэй байна.<br>7. Хөгжлийн хөтөлбөр намын аливаа үйл ажиллагаанд оролцогч этгээд намын үзэл баримтлал бодлого чиглэлийг дэмжин түүний хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх санал санаачлага гаргах хөтөлбөр дүрмийг боловсруулахад оролцох болон үндсэн мөрдлөгт нийцүүлэн гаргасан журмаар зохицуулагдах бүхий л эрх үүрэг эдэлнэ.<br>8. Хөгжлийн Хөтөлбөр Намын нээлттэй гишүүнчлэлээс татгалзах болон гишүүнчлэлийн хандив өгөх эсэх нь тухайн этгээдийг эрхэд хамаарна.<br>9.. Хөгжлийн Хөтөлбөр Намын хуулийн дагуух гишүүнчлэл нь аравтын системээр зохион байгуулагдана.<br>10. Намын ямарваа нэгэн үйл ажиллагаанд оролцохыг хүссэн этгээд нь өөрийн аравтыг зохион байгуулж гишүүнчлэлд хамрагдах бөгөөд аравтад багтах хүмүүс нь өөр намын төлөөлөлгүй намын гишүүнчлэлд хамрагдахыг зөвшөөрсөн байна.<br>11. Хуульд заасан гишүүнчлэлийн тоог хадгалах үүднээс гишүүнчлэлээс татгалзсан тохиолдол бүрт нэмэлт гишүүнчлэл явуулах, нөөц гишүүнчлэл үүсгэх, энэ талаар холбогдогдох байгууллагад ( Дээд шүүх) тогтмол мэдээлж баримт материалын хувийг өгөх зэрэг арга хэмжээг авч явна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМ** | 3.1.1. Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, дотоод журам, дүрмийг сайн дураараа зөвшөөрч тэдгээрийг биелүүлэхэд бодит идэвхи санаачлагатай оролцож, намын салбар хороодын аль нэгэнд ажиллан намын шийдвэрийг дагаж биелүүлдэг Монгол Улсын 18 нас хүрсэн иргэн Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намын гишүүн байж болно.<br>3.1.2. Намын гишүүн бүхэн намын гадаад, дотоод асуудалд чөлөөтэй саналаа илэрхийлж, намын бодлого санхүүг тогтвортой байлгахад санаачлага гарган ажиллана.<br>3.1.3. Намын гишүүн нь байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн анхан шатны байгууллагад бүртгэлтэй үнэмлэхтэй байна.<br>3.1.4. Намд гишүүн элсэх гишүүдийн шилжилт хөдөлгөөнийг журмаар зохицуулна.<br>3.1.5. Гишүүний улс төрийн албан тушаалд нэр дэвших, сонгох сонгогдох томилогдох үйл ажиллагааг журмаар зохицуулна.<br>3.1.6. Гишүүний хариуцлагыг тогтоосон журмын дагуу зохицуулна.<br>3.1.7. Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам эгнээндээ элсэхийг хүссэн хэн бүхнийг боловсрол, мэргэжил, яс үндэс, нас хүйс, гавьяа шагнал үл харгалзана. | 3.2. ЭЧХ Намын гишүүдийн үүрэг.<br>3.2.1.Намын эв нэгдэл, нягталыг бэхжүүлж, намын зөв бодлогыг гадаад, дотоодын хүтэн үймүүлэгчээс хамгаалж бодлогынхоо төлөө тууштай тэмцэгч байна.<br>3.2.2. Намын бодлогыг үргэлж шинээр цэнэглэж, бодлогын чадварыг сулруулахгүй байхын төлөө шийдвэртэй тэмцэж, улс орны ирээдүйн хөгжлийн төлөө улс төрийн бодлогын хар хайрцаг бий болгоход гар бие оролцож, нийгмийн хөгжингүй амьдралд оролцож, өөрийн болон бусдын сайн сайхан амьдралын төлөө цогтой тэмцэгч байх.<br>3.2.3. Яс үндэс, арьсны өнгө, боловсрол, гавьяа шагнал, эрхэлж байгаа албан тушаал, баян хоосны ялгаа харгалзахгүйгээр намын бүх гишүүд адилхан дагаж мөрдмөл зохих өөрийн намын болоод бусад нам, улсын сахилгыг чанд баримтлана.<br>3.2.4. Өөрийн боловсролыг цаг үргэлж дээшлүүлж, улс төрийн ноён нуруутай бодлого баримталж, иргэн ба ард түмний, улс үндэстний эрх чөлөөний тунхагийг боловсронгуй болгохын төлөө тууштай ажиллагч байх.<br>3.2.5. Намыг дэмжигч ба дэмжигч бус иргэдийн санал хүсэл, эрэлт хэрэгцээг анхааралтай сонсож намын анхан шатны байгууллага ба удирдлагад цаг алдалгүй уламжлан бодит шуурхай арга хэмжээ авах талаар анхаарлаа хандуулдаг байх.<br>3.2.6. Улс орноо хөгжүүлэхийн төлөө үзэл бодлыг дэмжиж, үйлдвэрлэлийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч улс орон болгохын төлөө өөрийн эзэмшсэн ажлын арга барил, үйлдвэрлэлийн технологыг бусдад эзэмшүүлэгч, үйлдвэрлэлд нэвтрүүлэгч, нийтийн болоод хувийн өмчийг хамгаалан нэмэгдүүлэгч байх.<br>3.2.7. Хэт ташуурган улс төржих, өөрийн ололтонд хийрхэн бардамнахыг үл тэвчихын зэрэгцүээ дээр дороос гарсан шүүмжлэлийг хөгжүүлж, ажлын дутагдлыг илрүүлэн арилгагч байх.<br>3.2.8. Эрх тэгш нийгэм, эрх чөлөөт төрийн төлөө эргэж буцашгүй тэмцэгч, өөрийн үзэл бодолдоо үнэнч шударга, нам болоод улс орны эрх ашигт үл нийцсэн асуудлуудтай үл эвлэрч байх ба намын эгнээ дэмжигчдийн хүрээг өргөтгөх намын байгууллагыг бэхжүүлэхэд идэвхи санаачлага гаргах.<br>3.2.9. Намын дотоод асуудлын нууцыг чандалж, улс эх орны ирээдүйн хөгжилтэй холбоотой асуудлаар цаг үргэлж намын бодлогыг цэнэглэх зорилгоор санал оруулж ирдэг байх.<br>3.2.10. ЭЧХН-н үзэл баримтлал мөрийн хөтөлбөр бодлогыг хэрэгжүүлэх Үндсэн дүрэм болон акт бичиг баримтанд нийцүүлэн гаргасан бусад журам шийдвэрийг дагаж мөрдөх.<br>3.2.11. Төрийн сонгуульд намаас болон бие даан нэр дэвшсэн ч намын үзэл баримтлалдаа үнэнч байх тэгэхдээ хуулийн дагуу намаас татгалзаж, шаардлагатай бол тусгай гэрээ хийсэн байх.<br>3.2.12. Намаас нэр дэвшигчдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх нэр дэвшиг, ЭЧХН-н болон бусад намын дэвшилттэй мөрийн хөтөлбөрийг дэмжиж, өөрийн намын хөтөлбөрийг сурталчлах.<br>3.2.13. Намын нэр хүнд эв нэгдлийг үзэл баримтлалын дагуу хамгаалах намын мөрийн хөтөлбөр үзэл баримтлалд үл нийцэх аливаа үйл ажиллагааг дэмжихгүй байх.<br>3.2.14. Намын дотоод асуудлыг дотооддоо шийдвэрлэдэг, гадаад улс орон, олон нийтэд хандаж намын нэр хүнд үзэл баримтлал мөрийн хөтөлбөрт харшлах сөрөг нөлөө бүхий үйлдэл хийхгүй ба бусдаар гаргуулахгүй байх.<br>3.2.15. Журмаар тогтоосон хэмжээний татвар төлдөг, сайн дурын үндсэн дээр барьцаалах журамгүйгээр намд хандивлагч, мөн хандивлагчийг олох түүнийг намтай холбож өгөх.<br>3.3. Намын гишүүний эрх.<br>3.3.1. Намын удирдлагыг сонгох, түүнд сонгогдох, бодлогыг боловсронгуй болгох талаар санал бодлоо чөлөөт зарчмаар илэрхийлэх, ажил хэргийн чанартайгаар хэлэлцэхэд оролцох.<br>3.3.2. Хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шүүмжлэх, шүүмжлүүлэх.<br>3.3.3. Өөрийн тухай болон ажил байдалтай холбоотой асуудал шийдвэрлэхэд биечилэн оролцох.<br>3.3.4. Намын боловсон хүчний хувьд намын эрх бүхий байгууллагын дэмжлэгээр улс төрийн албан тушаалд нэр дэвших, сонгох, сонгогдох, томилох, томилогдох.<br>3.3.5. Шаардлагатай гэж үзвэл намаар хамгаалүүлах, өөртэйгөө болон өөр бусадтай холбогдолтой асуудлыг намын аль ч салбараар дамжуулж удирдах байгууллагад хүргэх, өөгдөл санал гомдол бичих.<br>3.3.6. Намын бодлого үйл ажиллагаа, санхүүжилттэй холбоотой мэдээлэл авах. | 3.4. ЭЧХ Намаас гишүүнийг түдгэлзүүлэх, чөлөөлөх, хасах тухай<br>3.4.1. Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намын төв ба салбарын удирдлага шаардлагатай гэж үзвэл хориглох тухай зааптанд хамрагдагсдыг намаас хассан тухай тооцно.<br>3.4.2. . Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намаас тухайн гишүүн өөрөө татгалзвал.<br>3.4.3. Намын гишүүн хууль тогтоомжинд заасан үндэслэлээр түдгэлзэх бөгөөд энэ тухайгаа харьяалагдах шатны намд бичгээр мэдэгдэж бүртгүүлнэ.<br>3.4.4. Харьяалагдах намын анхан шатны байгууллагад мэдүүлснээс хойш 7 хоногийн дотор гишүүнийг бүх шатны намын бүртгэлээс хасуулахыг тухайн шатны намын байгууллага хариуцна.<br>3.4.5. Намын гишүүн нь намаас гарах тухайн хүсэлтээ үнэмлэхийнхээ хамт эргүүлэн өгнө.<br>3.4.6. Хэрэв 3.3.5 дахь заалт хугацаандаа хэрэгжээгүй бол гишүүнээс чөлөөлөгдсөнд тооцогдоно. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **АРД ТУМНИЙ НАМ** | 6 дугаар зүйл. Намд гишүүн элсүүлэх журам.<br>6.1. Монгол Улсын харьяат, 18 насанд хүрсэн хүн тус намд гишүүнээр элсэж болно.<br>6.2. Намд гишүүнээр элсэхийг хүссэн хүн өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрийн намын анхан шатны байгууллага /үүр/-д энэ тухайгаа өргөдөл гаргана. Ингэхдээ Хэрэг Эрхлэх газраас баталсан өргөдлийн загварыг бөглөх ба түүнд тухайн хүн гарын үсэг зурсан байвал зохино.<br>6.3. Тухайн намын байгууллага уг өргөдлийн дагуу түүнийг бүртгэн авч тус намын гишүүний үнэмлэхийг шууд гардуулна.<br>6.4. Оршин суугаа нутаг дэвсгэрт нь намын анхан шатны байгууллага байгуулаагүй бол тухайн аймаг, дүүргийн намын хороонд гишүүнээр элсэж болно. Энэ тохиолдолд энэ дүрмийн 6.2-т заасан журмыг нэг адил баримтлана. | 7 дугаар зүйл. Намын гишүүний эрх, үүрэг<br>7.1. Намын гишүүн дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:<br>7.1.1. Харьяалагдах намын байгууллагынхаа үйл ажиллагаанд тогтмол оролцож, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;<br>7.1.2. Намын орон нутгийн байгууллагын эрх барих болон төлөөллийн байгууллага, түүнчлэн намын удирдах дээд болон Төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнд сонгогдох;<br>7.1.3. Намын орон нутгийн байгууллагын удирдах болон төлөөллийн байгууллага, түүнчлэн намын удирдах дээд болон төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг сонгоход оролцох;<br>7.1.4. Намын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар намын аль ч байгууллага, удирдлагад санал тавих, мэдээлэл авах, шүүмжлэл гаргах, хариу авах;<br>7.1.5. Намын бодлогыг нийтэд сурталчлах;<br>7.1.6. Бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр намаас сайн дураар гарах буюу намд дахин элсэх;<br>7.1.7. Бүх шатны сонгуульд хууль тогтоомжид заасан журмын дагуу нэр дэвших;<br>7.1.8. Бүх шатны сонгуульд өөрийн намаас нэр дэвшигчийн талаар санал гаргах, нэр дэвшигчийг дэмжих, сурталчлах;<br>7.1.9. Намын дүрмийн дагуу гаргасан хамтын шийдвэрийг биелүүлэх;<br>7.1.10. Намаа үйл ажиллагаагараа буюу санхүүгийн талаар дэмжих;<br>7.1.11. Намын гишүүний болон сонгуульт гишүүнийхээ татварыг тогтоосон хугацаанд төлөх;<br>7.1.12. Шагнал, урамшуулал хүртэх;<br>7.1.13. Намын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх;<br>7.2. Тус намын гишүүн өөр намд давхар харьяалалтай байхыг хориглоно.<br>7.3. Намын гишүүний ёс зүйн дүрмийг намын “Бага хуралдай” батална. | | |
| **МОНГОЛЫН СОЦИАЛ ДЕМУКРАТ НАМ** | Зүйл 2. МСДН-ын гишүүн<br>МСДН-ын үзэл баримтлал, дүрмийг хүлээн зөвшөөрч, тус намд сайн дураар нэгдэн орох хүсэлтээ гарган, намын зохих байгууллагад бүртгүүлсэн, иргэний бүрэн эрх эдэлж, үүрэг хүлээдэг Монгол Улсын иргэн МСДН-ын гишүүн мөн.<br>МСДН-ын гишүүн нь үүнийг илэрхийлсэн батлахтай байна. | Зүйл 3. МСДН-ын гишүүний эрх, үүрэг<br>МСДН-ын гишүүн нь дор дурдсан эрхийг эдэлнэ.<br>1.Ардчилсан зарчмын үндсэн дээр намын аливаа байгууллагад сонгогдох буюу сонгох, төрийн байгууллагын сонгуульд намаас нэр дэвших буюу нэр дэвшүүлэх;<br>2.Төрийн байгууллагын удирдлагад намаас нэр дэвшин томилогдсон буюу төрийн байгууллагын сонгуульд намаас нэр дэвшсэн үедээ намаас зохих ёсны дэмжлэг авах;<br>3. Намын үйл ажиллагаанд хамаарагдах аливаа асуудлаар намын холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, хүсэлт гарган шийдвэрлүүлэх болон дүгнэлт, шүүмжлэл гаргах зэргээр шууд харилцах;<br>4. Энэхүү дүрэмд заасан журмын дагуу намын дотор жигүүр байгуулах буюу түүнд нэгдэн орох;<br>5. Хуулийн дагуу гишүүнээс түдгэлзэх;<br>6. Намын гишүүн буюу намаас нэр дэвшигч нэр төрөө хамгаалуулах зорилгоор намын байгууллагад хүсэлт гаргах.<br>МСДН-ын гишүүн дор дурдсан үүргийг биелүүлнэ.<br>1.Намын дүрмийг удирдлага болгон гаргасан хамтын шийдвэрт захирагдах;<br>2.Төрийн байгууллагын сонгуульд өөрийн намаас нэр дэвшигчийг дэмжих;<br>3.Сонгогч нарт өөрийн нам, түүнээс нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг таниулах;<br>4.Намдаа үйл ажиллагаа буюу санхүүгээр дэмжлэг үзүүлэх. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ НЭГДСЭН НАМ** | 4 дүгээр зүйл. Намд гишүүн элсүүлэх журам<br>1.Монгол Улсын харьяат. 18 нас хүрсэн иргэн тус намын гишүүнээр элсэж болон ба энэ тухайгаа өргөдөл гарган өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрийнхээ намын байгууллага (үүр)-д хүсэлт гаргана. Тухайн намын байгууллага уг өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногт багтаан өргөдөл гаргагчийг бүртгэн авч гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэн гишүүний үнэмлэх гардуулна.<br>2.Оршин амьдардаг нутаг дэвсгэрт нь намын үүр байгуулагдаагүй тохиолдолд тухайн иргэнийг аймаг, дүүргийн намын хороо гишүүнээр элсүүлж болно. | 3 дугаар зүйл. Намын гишүүний эрх, үүрэг<br>1.Намын гишүүн дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:<br>1)Харьяалагдах намын байгууллагынхаа үйл ажиллагаанд тогтмол оролцох.<br>2)Намын орон нутгийн эрх барих байгууллага болох Хурал болон удирдах төв байгууллагын бүрэлдэхүүнд тогтоосон журмын дагуу сонгогдох.<br>3)Намын эрх барих болон удирдах төв байгууллагын гишүүнийг сонгоход оролцох.<br>4)Намын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар намын орон нутгийн болон удирдах төв байгууллагаас санал, мэдээлэл авах, шүүмжлэл гаргах, хариу авах.<br>5)Намын бодлогыг нийтэд сурталчлах.<br>6)Бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр намаас сайн дураар гарах буюу намд дахин элсэх.<br>7)Бүх шатны сонгуульд, хууль тогтоомжинд заасан журмын дагуу нэр дэвших, сонгогдох.<br>8)Бүх шатны сонгуульд өөрийн намаас нэр дэвшигчийн талаах санал гаргах, нэр дэвшигчийг дэмжих, сурталчлах.<br>9)Намын удирдах төв байгууллагаас санал болгосны дагуу төрийн байгууллагын удирдах албан тушаалд тогтоосон журмын дагуу томилогдох.<br>10) Намын дүрмийн дагуу гаргасан хамтын шийдвэрийг биелүүлэх.<br>11)Намаа үйл ажиллагаагаараа буюу санхүүгийн талаар дэмжих.<br>12)Гишүүний татварыг тогтоосон хугацаанд төлөх.<br>13) Шагнал, урамшил хүртэх. | | |
| **БҮГД НАЙРАМДАХ НАМ** | 5 дугаар зүйл. Намын гишүүн<br>“Бүгд Найрамдах Намын гишүүний үнэмлэх” бүхий Монгол Улсын иргэн намын гишүүн байна.<br>6 дугаар зүйл. Намын гишүүн элсэх<br>6.1.Намын зорилго, мөрийн хөтөлбөр, дүрмийг бүрэн хүлээн зөвшөөрч буй 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн намд элсэх хүсэлтээ иргэний бүртгэлээр оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ намын байгууллагад бичгээр гаргана.<br>6.2. Энэ зүйлийн 1-д заасан намын байгууллага нь намд элсэхийг хүссэн иргэний хүсэлтийг хүлээн авсан өдрөөс эхлэн ажлын 3 хоногт багтаан хурлаараа хэлэлцэж, намд элсүүлж “гишүүний үнэмлэх” гардуулна. | 7 дугаар зүйл. Намын гишүүний эрх, үүрэг<br>7.1. Намын гишүүн дараах эрхтэй.<br>7.1.1. Намын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, санал тавих, шүүмжлэх, мэдээлэл авах, асуулт тавих, асуултанд хариу шаардаж авах.<br>7.1.2. Намын орон нутгийн эрх бүхий байгууллага болон удирдах төв байгууллагад тогтоосон журмын дагуу өөрийн болон бусдын нэрийг дэвшүүлэх.<br>7.1.3. УИХ болон нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуульд өөрийн болон бусдын нэрийг дэвшүүлэх.<br>7.1.4. Намын удирдах төв байгууллагаас санал болгосны дагуу төрийн байгууллагын удирдах албан тушаалд тогтоосон журмын дагуу томилогдох, намаас дэмжлэг авах.<br>7.1.5. Төрийн болон намын, мөн бусад байгууллагын шагналд тодорхойлуулах хүсэлтээ гаргах.<br>7.1.6. Бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр намаас сайн дураар гарах буюу намд дахин элсэх.<br>7.2. Намын гишүүн дараах үүрэгтэй.<br>7.2.1. Энэ дүрэм болон үүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, хэм хэмжээг сахин биелүүлэх.<br>7.2.2. Косерватив үзэл баримтлал, намын бодлого, шийдвэрийг нийтэд сурталчлах.<br>7.2.3. Харьяалагдах намын байгууллагынхаа үйл ажиллагаанд тогтмол оролцох.<br>7.2.4. Намын эрх барих болон удирдах төв байгууллагын гишүүн сонгоход оролцох. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 6.3. Оршин суугаа нутаг дэвсгэрт нь намын байгууллага байхгүй тохиолдолд намд гишүүнээр элсэхийг хүсэгч нь намын байгууллага бүхий газар намд элсэн орж болох бөгөөд намд гишүүнээр элсүүлэх асуудлыг нь тухайн орон нутгийн намын байгууллага шийдвэрлэнэ. | 7.2.5. Төрийн бүх шатны сонгуульд нэр дэвшигчийг дэмжих, сурталчлахтуслалцаа үзүүлэх.<br>7.2.6. Намын эгнээ, дэмжигчийн хүрээг өргөтгөх.<br>7.2.7. Намын өмч хөрөнгийг арвижуулах.<br>7.2.8. Энэ дүрмийн “8.1”-д заасан “намын гишүүний татварыг” тогтоосон хугацаанд төлөх.<br>7.3. Нам гишүүнээ намын үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар шаардлагатай тохиолдолд өмгөөлөлдөө авна.<br>7.4. Намын гишүүн нь өөр намын гишүүн байхыг хориглоно. | | |
| **МОНГОЛЫН ЛИБЕРАЛ НАМ** | 2.1. Гишүүнчлэл<br>2.1.1. Намын мөрийн хөтөлбөр, үзэл баримтлал, дүрмийг хүлээн зөвшөөрсөн Монгол Улсын 18 нас хүрсэн иргэн МЛН-ын гишүүнээр элсэж болно.<br>2.1.2. Гишүүн нь байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн анхан шатны байгууллагад бүртгэлтэй байна.<br>2.1.3. Гишүүн нь намаас түдгэлзэх асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.<br>2.1.4. Гишүүдээ нам дэмжин, сонгуулийн үед хүн хүч, цаг хөрөнгө, мэдээллээр хангана.<br>2.1.5. Гишүүн нь намаас сайн дураар гарч болох бөгөөд энэ турхйгаа анхан шатны байгууллагад бичгээр мэдэгдэж, бүртгэлээс хасуулна.<br>2.1.6. Монгол Улсын хууль болон МЛН-ын дүрмийг ноцтой зөрчсөн гишүүнийг намын сонгуульт албан үүргээс чөлөөлөх болон намын гишүүнээс хасах болно. | 2.2. Гишүүний эрх<br>2.2.1. Намын бүх шатны удирдах байгууллагад нэр дэвших, дэвшүүлэх, сонгогдох, сонгох.<br>2.2.2. Намын боловсон хүчний хувьд намын эрх бүхий байгууллагын дэмжлэгээр улс төрийн албан тушаалд сонгогдох, томилогдох.<br>2.2.3. Намын бодлого, үйл ажиллагаа санхүүжилттэй холбоотой мэдээлэл авах.<br>2.2.4. Намын бүх шатны байгууллагатай шууд харилцан санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, намын бодлого шийдвэрт тусгуулах.<br>2.2.5. Үзэл бодол, нэр төр, ёс зүйн хувьд намын өмгөөлөл, ивээлд багтах.<br>2.2.6. Гишүүний хувьд намын сан хөмрөгт хандив өргөх.<br><br>2.3. Гишүүний үүрэг<br>2.3.1. Намын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, намын шийдвэрийг хэрэгжүүлэх, мөрийн хөтөлбөр дүрэм, түүнд нийцүүлэн гаргасан бусад журмыг ёсчлон биелүүлэх.<br>2.3.2. Сонгуульд намаас нэр дэвшигчдэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх.<br>2.3.3. Төр засгийн байгууллагад сонгуулахаар буюу томилуулахаар нэр дэвшүүлсэн, санал болгосон намын байгууллагынхаа өмнө ажлаа намын гишүүний хувьд хариуцдаг, тайлагнадаг байх.<br>2.3.4. Улс үндэснийхээ эрх ашгийг дээдэлж, намын нэр хүнд, нэгдлийг хамгаадах. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **МОНГОЛЫН ЛИБЕРАЛ АРДЧИЛСАН НАМ** | Хоёр. Намын гишүүн, талархал<br>2.1. МоЛАН-ын үзэл бари мтлал, хөмөлбөр, дүрмийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхэд сайн дураараа үүрэг хүлээсэн Монгол Улсын 18 нас хүрсэн иргэн намд гишүүнээр элсэж болно.<br>Намд гишүүнээр элссэн иргэн харьяаллынхаа дагуу нутаг дэвсгэрийн намын анхан шатны байгууллагад бүртгүүлсэн гишүүн болсноо нотлох баримт бичигтэй байна. | 2.4. Намын гишүүний эрх<br>2.4.1. Намын аль ч байгуулгад нэрээ дэвшүүлэх, сонгогдох, томилогдох.<br>2.4.2. Намын үзэл онол, бодлого хөтөлбөр, бусад баримт бичгийг боловсруулахад оролцох, намын аль шатны байгууллага, гишүүний талаар хурал, цуглаан болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодол, байр суурия чөлөөтэй илэрхийлэх, намаас эвээл өмгөөлөл эрэх.<br>2.4.3. Бүх шатны сонгуульд намын өмнөөс нэр дэвшигчдийг шилж сонгоход санал гаргах, энэ талаар болон намын үйл ажиллагааны талаар мэдээлэх авах.<br>2.5. Намын гишүүний үүрэг<br>2.5.1. Намын аль нэг байгууллагад харьяалагдаж, намын үзэл улс төрийн бодлого, шийдвэрийг сурталчилж, хэрэгжүүлэхэд идэвхитэй зүтгэж, намын нийгмийн баазыг өргөтгөх тус дэм үзүүлэх;<br>2.5.2. Намаас бүх шатны сонгуульд оролцох хөтөлбөр, нэр дэвшигчдийг сурталчлах;<br>2.5.3. Намын бодлого, зорилгод болон гишүүдийн нэр төрд үл нийцэх аливаа үйлдэлтэй тэмцэх. | 2.7. Намын гишүүнээс гарах ба түдгэлзэх<br>2.7.1. Шилжилт хөдөлгөөн хийх, намаас дүтгэлзэх, гарахдаа нутаг дэвсгэрийн анхан шатны байгууллагад бүртгүүлэх, гарах тохиолдолд бүртгэлээс хасуулж, гишүүний үнэмлэхээ намын аль ч шатны байгууллагад эргүүлэн өгсөнөөр намаас гарсанд тооцно. | |
| | 2.2. Намын гишүүнээс түдгэлзэх, өөрийнхөө хүсэлтээр намаас гарах бүрэн чөлөөтэй.<br>2.3. Өөр намын гишүүн уг намаасаа гарсны дараа МоЛАН-д гишүүнээр элсэнэ. | 2.7.2. Намын гишүүний эрхлэж буй ажил нь хуулийн дагуу гишүүн намаас түдгэлзэх шаардлагатай бол өргөдлөө гаргаж намаас түдгэлзэнэ.<br>2.7.3. Намын дүрмийг ноцтой зөрчсөн гишүүнд намаас сануулж зэмлэл хүлээлгэж болно. Энэ талаарх намын байгууллагын шийдвэрийг намын аль ч шатны байгууллагад тавьж болно. Гомдлыг тухайн шатны намын байгууллага 21 хоногийн дотор шийдвэрлэнэ. | | |
| **ЭХ ОРОН НАМЫН ДҮРЭМ** | 1.1.Намын мөрийн хөтөлбөр, дүрмийг зөвшөөрч, бодлого үйл ажиллагааг нь дэмжихээ илэрхийлсэн, сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн тус намд гишүүнээр элсч болно. Намын гишүүн нь байнга оршиг суугаа орон нутгийн намын анхан шатны байгууллагад бүртгэлтэй, батламжтай байна. Намд сайэ дураараа элсэх тухай иргэний хүсэлтийг намын анхан шатны байгууллага шийдвэрлэнэ.<br>1.2. МАШСН, Эх орон МАШСН-ын гишүүн нь “Эх орон” намын гишүүн мөн.<br>1.3. Намын бодлого, үзэл баримтлалыг талархаж, намд сэтгэл санааны дэм үзүүлэх хүсэлтэй иргэнийг дэмжигч гэнэ. | 1.4. Гишүүний эрх<br>1.4.1. Санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, намын бодлого шийдвэрт, үзэл баримтлалд тусгуулах.<br>1.4.2. Намын удирдах байгууллагуудад нэр дэвших, дэвшүүлэх, сонгох, сонгогдох.<br>1.4.3. Намын эрх бүхий байгууллагын дэмжлэгтэйгээр төр, засгийн байгууллагад сонгогдох, томилогдох.<br>1.4.4. Нам түүний байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, үзэл бодол, нэр төр, ёс зүйн хувьд намын өмгөөлөл ивээлд багтах, намын байгууллага, гишүүдийн талаар шүүтжлэлтэй хандах.<br>1.4.5. Намын гишүүнийхээ хувьд мөшгин хавчих, заналхийлэх, гүтгэх, доромжлох, дарамтлах зэргээс хуулиар хамгаалуулах.<br>1.4.6. Өөртэйгээ холбогдсон асуудал хэлэлцэхэд биеэр оролцох.<br>1.4.7. Намын гишүүнээс түдгэлзэх, намаас өөрийн хүсэлтээр гарах.<br>1.5. Гишүүний үүрэг<br>1.5.1. Намын анхан шатны нэг байгууллагад харьяалагдаж намаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцож, намын мөрийн хөтөлбөр, бодлогыг сурталчлан хэрэгжүүлэх, намын эгнээ, дэмжигчдийн хүрээг өргөжүүлэхэд санаачлагатай ажиллах.<br>1.5.2. Намын үйл ажиллагааг дэмжин сар тутам 100 төгрөгийн татвар төлөх, намын хэвлэл захиалах.<br>1.5.3. Намаас төрийн бүх шатны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдийг сурталчлах.<br>1.5.4. Улс үндэсний эрх ашгийг дээдэлж, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулахын төлөө хүч оюунаа дайчлан ажиллах.<br>1.5.5. Намын гишүүн шилжилт хөдөлгөөнөө болон намаас түдгэлзсэнээ НАШБ-даа бүртгүүлж, намаас гарвал бүртгэлээс хасуулан батламжаа эргүүлэн өгнө. | 1.6. Намын бодлого, үйл ажиллагаа, нэр хүнд, эв нэгдэлд хохирол учруулсан, намаас нэр дэвшиж УИХ-д сонгогдсоныхоо дараа өөр нам эвслийн бүлэгт шилжсэн болон бүх шатны сонгуульд бие даан нэр дэвшсэн гишүүнийг намаас хасна. НАШБ-ын энэ шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо аймаг, дүүрэг /нийслэл/-ийг хороо, Хяналтын зөвлөлд гаргаж болно. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМ** | Дөрөвдүгээр бүлэг. Намын гишүүнчлэл.<br><br>1 дүгээр зүйл. Намд гишүүнээр элсэх<br>4.1.1. Намын үзэл баримтлал, дүрмийг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагааг сайн дураараа дэмжихээ илэрхийлж байгаа, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд бусад намын гишүүн биш Монгол Улсын иргэн намын гишүүнээр элсэх эрхтэй.<br>4.1.2. Гишүүн нь байнга оршин суугаа нутаг дэвсгэрийн намын анхан шатны байгууллагад бүртгэлтэй, батлахтай байна.<br>4.1.3. Намд гишүүн элсэх, гишүүдийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг тухайн шатны<br>намын байгууллага хариуцна. | 2 дугаар зүйл. Гишүүний эрх, үүрэг<br>4.2.1. Намын гишүүн нь дор дурдсан эрхтэй.<br>1/Намын бүх шатны байгуулагад аливаа асуулаар саналаа тавих, шийдвэрлүүлэх.<br>2/Намын бүх шатны байгуулагад нэр дэвших, дэвшүүлэх, сонгох, сонгогдох.<br>3/Намын боловсон хүчний хувьд намын эрх бүхий байгуулагын дэмжлэгээр улс төрийн албан тушаалд сонгогдох, томилогдох.<br>4/Намын үзэл баримтлал, бодлого боловсруулах, хэлэлцэх үйл ажиллагаанд оролцох, байр сууриа илэрхийлэх.<br>5/Намын бодлого, үйл ажиллагаа, санхүүжилттай холбоотой мэдээлэл авах.<br>6/ Намын байгууллагаас өөрийнх нь тухай хэлэлцэхэд биеэр оролцох.<br>7/ Намын гишүүнээс түдгэлзэх, намаас өөрийн хүсэлтээр гарах.<br>4.2.2. Намын гишүүн дор дурсан үүрэгтэй.<br>1/ Намын байгууллагад харьяалагдаж, намын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, намын үзэл баримтлал, бодлогыг сурталчлан дэлгэрүүлэх, намын шийдвэрийг хэрэгжүүлэх, намын дүрэм, журмыг ёсчлон биелүүлэх.<br>2/ Гишүүний татварыг тогтоосон хугацаанд төлөх.<br>3/ Намаас бүх шатны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийг сурталчлах, үйл ажиллагаанл нь дэмжлэг үзүүлэх.<br>4/Намын гишүүн, дэмжигчдийн хүрээг өргөтгөхөд тус дөхөм үзүүлэх.<br>5/Хандив өргөх болон бусад байдлаар намын сан хөмрөгийг арвижуулахад идэвхи санаачлага гаргах.<br>6/ Намын гишүүн нь оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ намд бүртгэлтэй, шилжилт хөдөлгөөнөө болон намаас түдгэлзсэнээ анхан шатны байгууллагад бүртгүүлэх. | здугаар зүйл. Намын гишүүнээс чөлөөлөх<br>4.3.1. Намын гишүүн нь намаас чөлөөлөгдөх хүсэлтээ харьяаллын дагуу тухайн шатны намд бичгээр иргүүлсэнээс хойш 30 хоногийн дотор гишүүнийг бүх шатны намын бүртгэлээс хасуулахыг тухайн шатны намын байгууллага хариуцна.<br>4.3.2. Дээр заасан хугацаанд хэрэгжээгүй ч тухайн гишүүнийг гишүүнээс чөлөөлөгдсөнд тооцно.<br>4.3.3. Шаардлагатай бол гишүүнээс чөлөөлөгдсөн тухай баримтыг тухайн шатны намын байгууллага албан ёсоор гарган өгч болно. | |
| **ИРГЭНИЙ ЗОРИГ-БҮГД НАЙРАМДАХ НАМ** | 6 дугаар зүйл. Намд гишүүн элсүүлэх журам.<br>6.1. Монгол Улсын харьяат, 18 насанд хүрсэн хүн тус намд гишүүнээр элсэж болно.<br>6.2. Намд гишүүнээр элсэхийг хүссэн хүн өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрийн намын анхан шатны байгууллага (үүр)-д энэ тухайгаа өргөдөл гаргана. Ингэхдээ Хэрэг эрхлэх газраас баталсан өргөдлийн загварыг бөглөө ба түүнд тухайн хүн гарын үсэг зурсан байвал зохино.<br>6.3. Тухайн намын байгууллага уг өргөдлийн дагуу түүнийг бүртгэн авч тус намын гишүүний үнэмлэхийг шууд гардуулна.<br>6.4. Оршин суугаа нутаг дэвсгэрт нь намын анхан шатны байгууллага байгуулагдаагүй бол тухайн аймаг, дүүргийн намын хороонд гишүүнээр элсэж болно. Энэ тохиолдолд энэ дүрмийн 6.2 –т заасан журмыг нэг адил баримтлана. | 7 дугаар зүйл. Намын гишүүний эрх, үүрэг<br>7.1. Намын гишүүн дараахь эрх, үүрэгтэй байна. Үүнд:<br>7.1.1. харьяалагдах намын байгууллагынхаа үйл ажиллагаанд тогтмол оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;<br>7.1.2. намын орон нутгийн байгууллагын эрх барих болон төлөөллийн байгууллага, түүнчлэн намын удирдах дээд болон Төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнд сонгогдох;<br>7.1.3. намын орон нутгийн байгууллагын удирдах болон төлөөллийн байгууллага, түүнчлэн намын удирдах дээд болон төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг сонгоход оролцох;<br>7.1.4. намын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар намын аль ч байгууллага, удирдлагад санал<br>тавих, мэдээлэл авах, шүүтжлэл гаргах, хариу авах;<br>7.1.5. намын бодлогыг нийтэд сурталчлах;<br>7.1.6. бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр намаас сайн дураар гарах буюу намд дахин элсэх;<br>7.1.7. бүх шатны сонгуульд хууль тогтоомжид заасан журмын дагуу нэр дэвших;<br>7.1.8. бүх шатны сонгуульд өөрийн намаас нэр дэвшигчийн талаар санал гаргах, нэр дэвшигчийг дэмжих, сурталчлах;<br>7.1.9. намын дүрмийн дагуу гаргасан хамтын шийдвэрийг биелүүлэх;<br>7.1.10. намаа үйл ажиллагаагаараа буюу санхүүгийн талаар дэмжих;<br>7.1.11. намын гишүүний болон сонгуульт гишүүнийхээ татварыг тогтоосон хугацаанд төлөх;<br>7.1.12. шагнал, урамшил хүртэх;<br>7.1.13. намын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх.<br>7.2. Тус намд гишүүн өөр намд давхар харьяалалтай байхыг хориглоно.<br>7.3. Намын гишүүний ёс зүйн дүрмийг Үндэсний хороо батална. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **МОНГОЛЫН НОГООН НАМ** | 2.1. Гишүүнчлэл<br>2.1.1. МНН-ын мөрийн хөтөлбөр, дүрмийг хүлээн зөвшөөрч, тус намд сайн дураар нэгдэн орол хүсэлтээ гарган намын зохих байгууллагад бүртгүүлсэн Монгол Улсын 18 нас хүрсэн иргэн намд гишүүнээр элсэж болно.<br>2.1.2. Гишүүн нь оршин суугаа нутаг дэвсгэрийн намын анхан шатны байгууллагад бүртгэлтэй, батлахтай байна.<br>2.1.3. Намаас сайн дурааараа гарч болох бөгөөд энэ тухайгаа өөрийн харьяаллын анхан шатны намын байгууллагадаа бичгээр мэдэгдэж, бүртгэлээс хасуулна.<br>2.1.4. Намаас өгсөн сануулгыг ул анхаарч намын дүрмийг удаа дараа зөрчсөн гишүүнийг зохих шатны намын байгууллагын шийдвэрээр намын гишүүнээс хасна. | 2.2. Гишүүний эрх<br>2.2.1. Төр, засгийн болон намын бүх шатны байгууллагад нэр дэвших, дэвшүүлэх, сонгогдох, сонгох.<br>2.2.2. Намын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авах, намын бүх шатны байгууллагатай шууд харилцах, санал бодлоо чөлөөтэй илэрхийлж намын бодлого шийдвэрт тусгуулах.<br>2.2.3. Намын гишүүн намдаа хуулийн хүрээнд хандив өргөх.<br>2.2.4. Намын гишүүнээс түдгэлзэх, намаас өөрийн хүсэлтээр гарах, дахин элсэх.<br><br>2.3. Гишүүний үүрэг, хариуцлага<br>2.3.1. Намын гишүүнчлэлийн татварыг цаг тухайд нь ьөлж, намын санхүүг бэхжүүлэх.<br>2.3.2. Намын өдөр дутмын үйл ажиллагаанд идэвхитэй оролцохын зэрэгцээ намын шийдвэрийг хэрэгжүүлэх, намын гишүүдийн эгнээ, дэмжигчдийн хүрээг өргөтгөхөд өөрийн хүчийг дайчлан ажиллах.<br>2.3.3. Өөрийн харьяаллын намын байгууллагаас өргөн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэж эргэж албан ёсоор тайлагнах.<br>2.3.4. Аливаа сонгуульд өөрийн намаас нэр дэвшигчдэд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх.<br>2.3.5.Намын сан хөмрөгийг нэмэгдүүлэхэд идэвхитэй оролцох.<br>2.3.6. Экологийн тэнцлийг хадгалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалахад олон нийтийн хяналтыг манлайлах.<br>2.3.7. Үүрэг, хариуцлагаа ухамсарлаагүй гишүүдийг тухайн харьяаллын намын байгууллагаас 2 удаа сануулга өгч, 3 дахь удаад намаас хасах хүртэл арга хэмжээг авч болно. | | |
| **ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМ** | 1 дүгээр зүйл. Намын гишүүнчлэл ба гишүүд дэмжигчдийн эрх, үүрэг<br>1.1.Намын мөрийн хөтөлбөр, дүрмийг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагааг нь дэмжихээ илэрхийлсэн Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал ялгаварлахгүйгээр “ИХ” намд гишүүнээр болон дэмжигч гишүүнээр элсэж болно.<br>1.2. Намд гишүүнээр болон дэмжигч гишүүнээр элсэхээ илэрхийлсэн иргэний хүсэлтийг намын анхан шатны байгууллага хүлээн авч 5 хоногт багтаан шийдвэрлэнэ. | 1.5. Гишүүд, дэмжигчид бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр намаас сайн дураараа гарах буюу намд дахин элсэх эрхтэй.<br>1.6. “ИХ” намд элссэн гишүүд, дэмжигчид оршин суугаа газрынхаа намын анхан шатны байгууллагад заавал бүртгүүлнэ.<br>1.7. Гишүүд, дэмжигчид намын үзэл баримтлал, бодлого боловсруулахад болон намаас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд оролуох эрхтэй.<br>1.8. Гишүүд, дэмжигчид нь намын зохих шатны удирдах байгууллагад нэр дэвших, дэвшүүоэх эрхтэй.<br>1.8. Гишүүд, дэмжигчид нь намын зохих шатны удирдах байгууллагад нэр дэвших, дэвшүүлэх эрхтэй.<br>1.9. Гишүүд, дэмжигчид нь бүх шатны сонгуульд өөрийн намаас нэр дэвшигчийн талаар санал гаргах, нэр дэвшигчийг дэмжих, сурталчлах үүрэгтэй.<br>1.10. Намын дотоод амьдралын хмуудлаар шүүмжлэх, санал тавих, хариу авах эрхтэй.<br>1.11. Намын байгууллагаас өөрийнх нь тухай хэлэлцэхэд биечлэн оролцох эрхтэй.<br>1.12. Үзэл бодол, нэр төр, ёс зүйн хувьд намын улс төрийн хамгаалал хүртэх эрхтэй.<br>1.13. Намд туслах зорилгоор тухайн нутаг дэвсгэр дэх намын анхан шатны байгууллагын дэргэд зөвлөл, бүлгэм, клуб, холбоо байгуулах, эсхүл түүнд нэгдэж ажиллах эрхтэй. | 2 дугаар зүйл. Намын гишүүнчлэлээс чөлөөлөх<br>2.1. Гишүүн, дэмжигчид чөлөөлөгдөх хүсэлтээ харьяаллын дагуу аль нэг шатны намын байгууллагад бичгээр ирүүлснээс хойш 30 хоногийн дотор гишүүнийг бүх шатны намын бүртгэлээс хасуулахыг тухайн үатны нам хариуцна.<br>2.2. Хэрэв өмнөх заалт дээр заасан хугацаанд хэрэгжээгүй бол гишүүнээс чөлөөлөгдсөнд тооцно. | |

| | | | |
|---|---|---|---|
| | 1.3. Оршин амьдардаг нутаг дэвсгэрт нь намын анхан шатны байгууллага байгуулагдаагүй тохиолдолд аймаг, дүүргийн намын хороо тухайн иргэнийг гишүүн болон дэмжигчээр элсүүлж болно.<br>1.4. Намд элссэн гишүүд, дэмжигчдэд түүнийг элсүүсэн байгууллага, намын гишүүний болон дэмжигчийн үнэмлэх олгоно. | 1.14. Намаа үйл ажиллагаагаараа болон санхүүгийн талаар дэмжих эрхтэй.<br>1.15. Намын удирдах төв байгууллагаас санал болгосны дагуу төрийн байгууллагын удирдах албан тушаалд тогтоосон журмын дагуу томилогдох эрхтэй.<br>1.16. Намын эрх ашигт үл нийцэх улс төрийн аливаа үйл ажиллагааг дэмжихгүй байх, намын нэр хүнд, эв нэгдлийг хамгаалах үүрэгтэй.<br>1.17. Гишүүний татвараа тогтоосон хугацаанд төлөх үүрэгтэй.<br>1.18. Улс төрийн нам, хөдөлгөөн, холбооны гишүүн нь давхар “ИХ” намын дэмжигч байж болно.<br>1.19. Дэмжигч нь намын үзэл санаа, зарчим, бодлогыг дэмжиж намын үйл ажиллагаанд тодорхой хүрээнд оролцох эрхтэй бөгөөд зөвхөн тухайн эрхийнхээ хүрээнд үүрэг хүлээнэ. | |

- МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД УЛСЫН БҮРТГЭЛТЭЙ УЛС ТӨРИЙН НАМУУДЫН МЭДЭЭЛЭЛ-1

| дд | Намын нэр | Анх байгуулагдсан он | Үйл ажиллагааны чиглэл, Өмчийн хэлбэр | Гишүүдийн тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Монгол Ардын нам /МАН | 1921.03.01 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 161300 |
| 2 | Ардчилсан нам | 2000.12.25 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 150000 |
| 3 | Монголын Ногоон нам /МНН/ | 1990.05.13 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 2100 |
| 4 | Иргэний Зориг нам /ИЗН/ | 2000.03.09 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 35000 |
| 5 | Монголын Уламжлалын Нэгдсэн нам / МУНН/ | 1993.12.05 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 1503 |
| 6 | Монголын Либерал Ардчилсан Нам /МЛАН/ | 1998.05.21 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 863 |
| 7 | Эх Орон нам | 1998.12.22 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 160.000 |
| 8 | Монголын Либерал Нам /МЛН/ | 1999.12.17 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 1300 |
| 9 | Бүгд Найрамдах Нам /БНН/ | 2004.03.15 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 50000 |
| 10 | Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нэгдсэн Нам /МЭҮНН/ | 2004.4.12 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 1069 |
| 11 | Монголын Социал Демократ Нам | 2004.12.19 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 3000 |
| 12 | Ард Түмний Нам /АТН/ | 2005.12.11 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 11859 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | Үндэсний Шинэ Нам | 2006.05.19 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 2400 |
| 14 | Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам | 2006.10.09 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 1600 |
| 15 | Иргэний Хөдөлгөөн Нам /ИХ/ | 2007.08.17 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 815 |
| 16 | Хөгжлийн Хөтөлбөр Нам | 2007.10.28 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 933 |
| 17 | Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам | 2008.02.01 | Улс төрийн, О/Н/Өмчийн | 850 |

- МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД УЛСЫН БҮРТГЭЛТЭЙ УЛС ТӨРИЙН НАМУУДЫН МЭДЭЭЛЭЛ-2

| Д/д | Намын нэр | Регистрын дугаар | Дэлгэрэнгүй хаяг | Утасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Монгол Ардын нам /МАН | 8488908 | Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө, Нийслэлийн хүүхэд залуучуудын газар, МАХН-ын төв байр | 323245 |
| 2 | Ардчилсан нам | 8488916 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Сүхбаатарын талбай-8, Ардчилсан намын төв байр | 262055, 264221, 318210, 262862, 312862 |
| 3 | Монголын Ногоон нам /МНН/ | 8488924 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Жамъянгүний гудамж Үндэсний бүтээмж төвийн байрны 204 тоот | 99114503 99113387 96651536 |
| 4 | Иргэний Зориг нам /ИЗН/ | 8488932 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-24/2, Иргэний Зориг намын хэрэг эрхлэх газар, | 99098741 99113264 |
| 5. | Монголын Уламжлалын Нэгдсэн нам / МУНН/ | 8488959 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингүүдийн гудамж,, “Мика” зочид буудал, 3 тоот , | 99710095 99191673 99114567 91910970 |
| 6 | Монголын Либерал Ардчилсан Нам / МЛАН/ | | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, “Жамъян гүн” гудамж-4, урд жигүүрийн өрөөнүүд түрээсээр | 319747, 323686, 323860 |
| 7 | Эх Орон нам | 8488975 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Жуковын өргөн чөлөө-7а, Эх орон намын төв байр, | 453178, 90150268 |
| 8 | Монголын Либерал Нам / МЛН/ | 8488983 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Соёлын коллежийн ар талд 3 давхар шар байшин, Улаанбаатар эрдэм Оюу Дээд сургууль дээр байрладаг. | 319039, 99852957 99870485 99872286 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | Бүгд Найрамдах Нам /БНН/ | 8488991 | Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Буян холдинг ХХК-ийн байр 106 тоот, | 99130905<br>91917443<br>99857099 |
| 10 | Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нэгдсэн Нам /МЭҮНН/ | | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж, “Шувуун саарал” УҮГ-ын “Б” корпус 3 давхарт | 324877 |
| 11 | Монголын Социал Демократ Нам | 8489009 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 5 дугаар байрны 12 тоот | 99114273<br>91177272 |
| 12 | Ард Түмний Нам /АТН/ | 8489017 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороонд орших “Бат-Сарай” ХХК-ийн Лаки төвийн байрны 3 дугаар давхарт 301 тоот өрөө | 99114140<br>91144343<br>99681212 |
| 13 | Үндэсний Шинэ Нам | 8489025 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө 12-ын 2 дугаар байр 1 дүгээр орц 4 тоот | 260535, 265625,<br>99179915<br>99684608<br>99116001 |
| 14 | Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам | 8489033 | Улаанбаатар, Баянгол дүүрэг 1 дүгээр хороо, Варьете төв | 309055,<br>368952 |
| 15 | Иргэний Хөдөлгөөн Нам /ИХ/ | 8489041 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу-49 Мэдээллийн технологийн үндэсний парк 304 тоот | 321900<br>99111403 |
| 16 | Хөгжлийн Хөтөлбөр Нам | 8489068 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо 7-н буудал дахь “Ядууралтай тэмцэх Хөгжлийн хөтөлбөр сан”-гийн байр 2 тоот | 96019222 |
| 17 | Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам | 8489076 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо Их сургуулийн гудамж 3/2, 306 тоот | 210620 99009093<br>91999901,<br>99825653 |

* * *

## 3. МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН НАМЫН ХАРЬЯАЛАЛЫН ТАЛААРХИ СУДАЛГАА

Үндэсний түвшинд 1990 онд Монгол Улс коммунист улс төрийн тогтолцооноос хүний эрхийг дээдэлсэн, иргэд чөлөөтэй, нээлттэй оролцдог ардчилсан тогтолцоонд шилжсэн. Монгол Улсын Үндсэн Хууль, Иргэний, Төрийн Бус Байгууллагын, Улс төрийн намуудын, Жагсаал цуглаан зохион байгуулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, Засгийн газрын тухай хуулиудын хүрээнд иргэдийн улс төрийн оролцоог зохицуулж байна.

Иргэний нийгмийн талаар хийгдсэн хамгийн сүүлийн судалгаагаар хүн амын бараг тэн хагас нь буюу 45.3 хувь нь ямар нэг иргэний нийгмийн байгууллагын гишүүн байна гэсэн дүнг гаргасан бөгөөд хамгийн өндөр нь улс төрийн намын гишүүнчлэл 2005 онд 41.5 хувь, 2008 онд 38.6 хувь (*энэ тоо 3 пунктээр буураагүй бөгөөд зөвхөн 2005 оны сонгуулийн насны иргэдийн тоо 2008 оны 3 дугаар сарын Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын Төвөөс гаргасан тооны зөрүүгээр буурсан*) үйлдвэрчний эвлэлд 14.1 хувь, ТББ-уудад 4.4 хувь нь албан ёсоор бүртгэгдэж, иргэний болон улс төрийн эрхээ эдэлж байна.

Улс төрийн намд гишүүнээр элсэнэ гэдэг бол улс төрийн оролцооны хамгийн идэвхтэй,

тогтвортой хэлбэр бөгөөд иргэдийн улс төрийн сонирхлыг илэрхийлэх, нэгтгэх, хэрэгжүүлэх өвөрмөц үүрэгтэй улс төрийн институц юм. Монголд өнөөдөр 17 улс төрийн нам Улсын Дээд Шүүхэд бүртгэлтэй байгаа ч сонгуулийн үед сонгогчдоос тогтмол дэмжлэг авдаг, засаглалыг хэрэгжүүлж чадахуйц МАХН, Ардчилсан нам гэсэн хоёр намаас өөр сонгогчдын итгэлийг даах улс төрийн нам алга байна.

Монголчуудын 10 хүн тутмын 4 нь ямар нэг намын гишүүн байгаа явдал бол улс төрийн оролцоо идэвхтэй байгаагийн илэрхийлэл гэж болно. Мөн үүний зэрэгцээ 4 жилийн хугацаанд Монголын улс төрийн амьдралд гарч ирсэн шинэ зүйл бол иргэний хөдөлгөөн бөгөөд өнөөдрийн байдлаар улс төрийн 62 хөдөлгөөн /2006 оны мэдээ/ ХЗДХ-ийн яаманд албан ёсоор бүртгэлтэй байна. Эдгээр хөдөлгөөнүүдээс идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 10 гаруй иргэний хөдөлгөөн байдаг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд оролцсон дэмжигчдийн албан ёсны тоо, жилд хэдэн жагсаал, цуглаан зохион байгуулсан талаарх мэдээлэл одоохондоо албан ёсоор гараагүй байна.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд улс төрийн гэхээс илүү байгаль орчин, түүх соёлоо хамгаалах албан ёсны бүртгэлтэй болон бүртгэлгүй байгууллага, иргэдийн хамтлаг “хөдөлгөөн” зэрэг нэртэйгээр олноор зохион байгуулагдаж байна.

Мэргэжлийн болон сонирхогчдын клуб, дугуйлангууд ч бас ордог. Нийтдээ эдгээр сайн дурын шинжтэй клуб, дугуйлан, ТББ, эвсэл, холбоо, хөдөлгөөнийг өнөөдөр манай улсад төрийн бус байгууллага /ТББ/ гэсэн статустайгаар хуулийн этгээдийн гэрчилгээг ХЗДХ-ийн яамнаас олгож байна. Өнөөдөр 7000 гаруй ТББ бүртгэгдсэн байна. Энэ нь мөн иргэд сайн дураар улс төр болон нийгмийн амьдралд идэвхтэй оролцож байгааг илэрхийлж байна.
Улс төрийн оролцооны нэг хэлбэр бол иргэд албны шугамаар интернет болон захидлаар өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэх хэлбэр багтдаг. Ялангуяа засгийн газрын төвшинд иргэд өргөдөл, гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх асуудал чухал байдаг. 1992 оноос хойш өнөөг хүртэл иргэдийн оролцооны энэ хэлбэр маш бага үзүүлэлттэй байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд дунджаар 1000 гаруй асуудлыг шийдвэрлэж иржээ.

Судалгаанаас үзэхэд Монголчууд улс төрийг түгээмэл сонирхдог бөгөөд хүйсээр ангилвал улс төрийг эрэгтэйчүүд илүү их сонирхдог байна. 2005 онд Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт боловсруулах социологийн судалгаанд оролцогчдоос сонгуульд хэрхэн оролцдог талаар асуухад 76.1 хувь нь байнга, 17.7 хувь алдаг оног, 6.2 хувь нь огт оролцдоггүй гэж хариулсан бол нийгэм, улс төрийн амьдралын дараах асуудлуудад хэрхэн оролцдог тухайд тодруулахад жагсаал, цуглаанд 26.7 хувь оролцдог, орон нутгийн удирдлагуудад хандаж байсан гэж 32 хувь, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандаж байсан гэж 11.9 хувь, улс төрийн намуудад хандаж байсан гэж 16.5 хувь, УИХ-ын гишүүнд хандаж байсан гэж 19.2 хувь, сонгуулийн сурталчилгаанд оролцож байсан гэж 39.6 хувь тус тус хариулсан байна. Эндээс харахад сонгуулийн бус иргэний идэвх санаачлагад тулгуурласан оролцооны хэлбэрт бага анхаардаг болох нь харагдаж байна.

Улс төрийн жагсаал, цуглаанд оролцож байсан тухайд 1 удаа оролцсон гэж 4.1 хувь, хэд хэдэн удаа оролцсон гэж 2.9 хувь, огт оролцож байгаагүй гэж 93 хувь нь хариулсан байна. Азийн 9 орны судалгааны дүнтэй харьцуулахад албан бус оролцооны хандлага өндөр харагдаж байна.

Гэр бүл, хамаатан садан, эсвэл хөршийн асуудлаар төр, захиргааны байгууллагад хандаж байсан эсэхийг Азийн барометр судалгаагаар тандсаж үзэхэд хангалтгүй оролцдог байна. Азийн 8 оронтой харьцуулсан Монгол Улс дундаж үзүүлэлттэй байна.

**Сонгуулийн оролцоо**

Монголчууд сонгуульд маш өндөр ирцтэй оролцдог боловч өнгөрсөн 5 удаагийн УИХ-ын

сонгууль, 4 удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын оролцоо жил ирэх бүр буурч байна. Гэхдээ албан ёсны оролцооны энэ бууралт нь ардчилал өндөр хөгжсөн орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр бөгөөд цаашид ч монгол улс дахь сонгуулийн оролцооны ирц буурах хандлагатай байна.

Судалгааг Өмнөговь аймгийн түвшинд нарийвчлан хийлээ. Улс төрийн намын гишүүнчлэлийн тухай асуудал нь иргэдийн улс төрийн оролцооны илэрхийлэл бөгөөд Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн суурь судалгаанд хамрагдсан 1325 оролцогчийн 39.2 хувь буюу 520 оролцогч нь ямар нэг намд гишүүнчлэлтэй байгаа нь улсын дундажтай ойролцоо байна. Намын гишүүнчлэлийн дээрх тоог сумдаар ангилахад Булган, Цогт-Овоо, Баяндалай, Сэврэй сумууд 52.1-66.7 хувьтай байгаа нь бусад 11 сумаас харьцангуй өндөр байгаа нь харагдаж байна. Харин Цогтцэций, Баян-Овоо, Манлай, Ханбогд, Даланзадгад, Гурвантэс сумд 26.9-34.8 хувьтай байгаа нь бусдаас харьцангуй бага байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын УДШ-д улс төрийн 17 нам бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрт 598896 намын гишүүн бүртгэлтэй байдаг. Энэ нь одоогийн байдлаар насанд хүрсэн нийт хүний 39 орчим хувь болж байна. Нийт намын гишүүдийг элссэн намаар нь ангилахад МАХН 26.9 хувь, Ардчилсан нам 25 хувь, бусад намууд 48.1 хувийг эзэлж байна. Харин Өмнөговь аймгийн намын гишүүдийн 60 орчим хувь МАХН-ын гишүүн, 37.6 хувь АН-ын гишүүн, 2.4 хувь нь бусад намын гишүүн байна.

Улс төрийн намын гишүүдийн эзлэх хувийг МАН, Ардчилсан нам ба бусад нам гэсэн ангиллаар аймгийн болон сумын төв, хөдөөгийн иргэдийн дунд эзлэх хувийг шинжлэхэд сум бүр харилцан адилгүй, мөн сумын төвийн болон хөдөөгийн иргэдийн хувьд ч мөн ялгавартай байгаа нь харагдаж байна. Жишээлбэл, Баяндалай сумын малчдын дунд АН илүү дэмжлэг авдаг, гишүүнчлэл өндөр байхад сумын төвд МАН-ыг илүү дэмждэг гишүүдийн эзлэх хувь өндөр байна. Харин Баян-Овоо, Гурвантэс, Манлай, Сэврэй, Ханбогд, Ханхонгор, Цогтцэций сумын бүх төвшинд МАН илүү дэмжлэг авдаг, гишүүнчлэл өндөр байхад АН гишүүнчлэлийн хувьд бага, дэмжлэг сул байна

Иргэд улс төрийн нөхцөл байдалд үнэлэлт өгч буй нь ардчилсан засаглалын илрэл, үнэт зүйл бөгөөд төр засгийн газрын хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг шүүмжлэх эсвэл сайшаах эрхтэй билээ. Өмнөговь аймгийн иргэд улс төрийн нөхцөл байдлыг “Сайн” гэж 12.2-21.3 хувь нь үзэж байхад “Дунд” гэж 49.7-52.1 хувь нь дүгнэж байна. Энэ нь өнөөгийн улс төрийн нөхцөл байдлыг хангалтгүй гэж үнэлж байгаа нь харагдаж байна. Үндэсний хэмжээнд сайн гэсэн үнэлэлт бага байхад сумын хэмжээнд эсрэгээр өндөр байна.

Улс төрийн нөхцөл байдлын “сайн” гэж үнэлэлтийг бүх сумдаар шинжлэхэд сумын түвшин дэх улс төрийн нөхцөл байдлыг аймгийн түвшнөөс илүү сайн гэж дүгнэж байхад үндэсний хэмжээн дэх улс төрийг аймгаас доогуур үнэлсэн байна. Үндэсний хэмжээнд улс төрийн нөхцөл байдлыг хэрхэн үнэлж буй үнэлгээг аймгийн болон сумын төв, хөдөөгийн иргэдтэй харьцуулах нь орон нутаг дахь ажил эрхлэлт, засаг захиргааны нэгжээс хамааралтай. Судалгаанд оролцогчид үндэсний хэмжээнд болж буй улс төрийн үйл явцыг хангалттай сайн гэж үнэлж чадахгүй байгаа нь харагдаж байна. Аймгийн дундаж нь сумын төвийн болон хөдөөгийн малчин иргэдийн улс төрийн талаарх үнэлгээ харилцан адилгүй байна.

Өмнөговь аймгийн улс төрийн нөхцөл байдлын талаар иргэдээс өгч байгаа үнэлгээ нь орон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого, үйл ажиллагааг хэр хүлээж авч байгааг илэрхийлсэн үзүүлэлт бөгөөд судалгаанд оролцогчид аймгийн хэмжээнд болж буй улс төрийн үйл явцыг хангалттай сайн гэж үнэлж чадахгүй байгаа ч үндэсний хэмжээн дэх улс төрийн үнэлгээнээс хавьгүй дээр харагдаж байна. Судалгаанд оролцогчид сум, орон нутгийн хэмжээнд болж буй улс төрийн үйл явцыг таван хүний нэг нь сайн, тал хувь

нь дунд зэрэг гэж үнэлж байна. Сумын төвийнхний 17.7 хувь, малчдын 23.5 хувь нь улс төрийн нөхцөл байдал сумын түвшинд ямар байгааг мэдэхгүй гэжээ. Иргэд улс төрийн институцийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх нь тухайн институцийн үйл ажиллагаа иргэдийн бодит хэрэгцээг хангаж чадаж байгаа эсэхийг тодруулах ач холбогдолтой байдаг.

Ерөнхийлөгчийн институцид итгэх итгэл

Өмнөговь аймгийн иргэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн институцээс хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааг хангалттай сайн гэж үнэлж байна. Аймгийн дунджаас сумын төвийн иргэд харьцангуй сайн гэж үнэлж байна. Мандал-Овоо, Ханхонгор, Цогт-Овоо сумын төвийн иргэд, Мандал-Овоо, Гурвантэс, Номгоны малчид ерөнхийлөгчийн үйл ажиллагааг илүү өндөр үнэлж байв.

УИХ-ын институцид итгэх итгэл

Өмнөговь аймгийн иргэд Улсын Их хурлын институцээс гаргасан хууль, тогтоол, улс орны хөгжлийг тодорхойлсон бодлого, үйл ажиллагааг хангалттай сайн гэж 10.6 хувь, дунд гэж 53.5 хувь, муу гэж 21.1 хувь нь үзэж байна.

МУ-ын Засгийн газарт итгэх итгэл

Өмнөговь аймгийн иргэд Монгол Улсын Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааг хангалттай сайн гэж үзэхгүй байгаа бөгөөд ерөнхийдөө дунд гэж (48.2%) үнэлж байна.

Сонгуульд оролцох хүчин зүйлс

Сонгогчид сонгуульд оролцож саналаа өгөхдөө маш олон хүчин зүйлсийг харгалзаж үздэг бөгөөд ерөнхийдөө энэхүү судалгаанд гол гэж үзсэн “намын харъяалал”, “мөрийн хөтөлбөр”, “хувь хүний чанар” шалгуурыг тодруулахыг хүссэн юм. Судалгаанд хамрагдсан нийт хүмүүс ерөнхийдөө улс төрийн намын мөрийн хөтөлбөр буюу бодлогыг, мөн нэр дэвшигчийн хувь хүний чанарт ач холбогдол өгч сонголтоо хийдэг болох нь харагдаж байна.

Сонгуульд оролцохдоо намын мөрийн хөтөлбөрийг харгалздаг гэсэн үзүүлэлтийг шинжлэхэд:

- Ханхонгор, Сэврэй, Мандал-Овоо, Ханбогд, Хүрмэн, Баян-Овоо, Баяндалай, Манлай сумд улс төрийн сонгуульд нэр дэвшигчийг ямар намаас нэр дэвшив гэдгийг илүү харгалздаг болох нь харагдаж байна.
- Номгон, Даланзадгад, Ноён, Баян-Овоо, Хүрмэн, Сэврэй, Баяндалай, Гурвантэс сум намын мөрийн хөтөлбөрт аймгийн дунджаас илүү ач холбогдол өгч байгаа нь харагдаж байна.
- Сонгуульд оролцохдоо хувь хүний чанарыг харгалздаг гэсэн үзүүлэлтийг шинжлэхэд Цогт-Овоо, Гурвантэс, Булган, Мандал-Овоо, Ноён, Сэврэй, Баяндалай сумдад улс төрийн сонгуульд саналаа өгөхдөө хүн чанарыг илүү харж саналаа өгдөг ажээ.

Улс төрийн намын дэмжлэг

Сонгуулийн үед аль нам хэдэн хувийн дэмжлэг сонгогчдоос авсан бэ? гэдэг асуудал бол орчин үеийн улс төрийн намуудын бодит дэмжлэгийг тодорхойлох тулгуур асуулт бөгөөд иргэд үндэсний болон орон нутгийн төвшинд ямар улс төрийн хүчнээр удирдуулахыг хүсэж буйг илэрхийлж байдаг. Мэдээж үндэсний хэмжээнд олонхийн саналыг авдаг, засаглалыг хэрэгжүүлэх чадвартай МАН, Ардчилсан намын тухайд шинжиллээ.

Үндэсний хэмжээнд МАН-ыг дэмжих дэмжлэг тус аймагт бусад намтай харьцуулахад өндөр

байна. Харин сумын төвийнхөн болон хөдөөгийн малчин иргэдийн хувьд энэ хандлага нь аймгийн дундаж дүнгээс арай дээгүүр байгаа нь харагдаж байна.

Ардчилсан намыг дэмжих явдал бас л харьцангуй өндөр байгаа боловч МАН-ын хэмжээнд хүрэхгүй байна. Харин сум болон хөдөөгийн малчин иргэдийн хувьд энэ хандлага нь аймгийн дундаж дүнгээс доогуур байна. Орон нутгийн түвшинд иргэд нутгийн удирдлагад МАН-ын төлөөллийг ажиллуулахыг дэмждэг хандлага харагдаж байна. Харин сумын төвийн болон хөдөөгийн малчин иргэдийн хувьд энэ хандлага нь аймгийн дундаж дүнгээс дээгүүр байна. Орон нутагт Ардчилсан намыг дэмждэг хандлага байгаа ч энэ нь МАН-аас их биш байна. Харин сум болон хөдөөгийн малчин иргэдийн хувьд энэ хандлага нь аймгийн дундаж дүнгээс доогуур байна.

## 4. НАМ ГИШҮҮНЧЛЭЛГҮЙ БАЙХ АСУУДЛААРХИ УЛС ТӨРИЙН ХҮЧИН БОЛОН ИРГЭДИЙН САНАЛ БОДОЛ

- Нам гишүүнчлэлгүй байх асуудлаархи улс төрийн хүчний гишүүдийн санал бодол

Улс төрийн нам гишүүнчлэлгүй байх асуудлаар улс төрийн намын дарга болон УИХ-ын зарим гишүүний хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлд өгсөн ярилцлагаас уг асуудлаархи тэдний санал бодлыг түүвэрлэн авав.Тухайлбал:

Гишүүн С.Ламбаа /АН/: Намууд гишүүнчлэлгүй болно гэдэг хамгийн зөв. Эмч, багш нарыг намын харьяалалгүй болгосноос хойш орон нутагт үндсэндээ ажилгүйчүүд, малчид л намын гишүүнээрээ үлдсэн шүү дээ.

Гишүүн С.Оюун /ИЗНын дарга/: Намууд гишүүнчлэлгүй болохыг дэмжиж байна. Нийгэм талцалгүй болно. Сонгуулийн үед иргэд мөрийн хөтөлбөрийг нь дэмжсэн намаа сонгоод явах нь зүйтэй.

Гишүүн Ц.Батбаяр /МАН/: Нам гишүүнтэй байх ёстой. Нам гэдгийн утга нь гишүүддээ байдаг.

Гишүүн Су.Батболд /МАН/: Пропорциональ систем рүү сонгууль шилжвэл нам гишүүнчлэлгүй байхад хэцүү. Одоохондоо гишүүнчлэлтэй байгаад яваандаа байхгүй болж болно. Сүүлийн үед намд харьяалалтай хүний тоо харьцангуй цөөрч байгаа.

Гишүүн Я.Батсуурь /АН/: Энэ бол УИХ-ын гишүүдийн дунд яригдаж буй олон санаануудын нэг л дээ. Зарим жижиг намуудаас ийм саналыг дэвшүүлдэг юм билээ. Улс төрийн намуудыг гишүүнчлэлгүй болгох, эсвэл хязгаарлагдмал гишүүнчлэлтэй болгох. Жишээлбэл нэг нам 800-аас, эсвэл 1000-аас илүүгүй гишүүнтэй байх. Яагаад гэвэл улс төрийн албан тушаал чинь цөөхөн шүү дээ. Засгийн газрын болон УИХ-ын гишүүд, дэд сайд, Засаг дарга нар л улс төрийн албан тушаалтан. Тиймээс улс төрийн намын гишүүний тоо бас хязгаартай буюу гишүүнчлэлгүй байх тухай яригдаад байгаа юм. Тийм учраас энэ санааг би хувьдаа дэмжиж байгаа. Энэ нь мөн манай нийгмийг хэт их улс төржилтөөс ангижруулахад ихээхэн тустай алхам болно.

Гишүүн Р.Гончигдорж /АН/: Гишүүнчлэлгүй байна гэдгийн хувьд Үндсэн хуулиар иргэд эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам бол иргэд сайн дураар эвлэлдэн нэгдэх нэг хэлбэр. Тэгэхээр шууд гишүүнчлэлгүй байна гэж хэлэхэд эрт байна.

Гишүүн Д.Оюунхорол /МАН/: Улс төрийн намуудын тухай хууль, Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулж яваандаа нам хатуу гишүүнчлэлгүй байж болох юм. Өнөөдөр сум, баг, өрх гэрээрээ намчирхсан үзэлд талцан хуваагдаад байгаа байдлыг арилгах шаардлагатай. Эв нэгдлийг илэрхийлэх ёстой нам гэдэг чинь өөрөө задрал руу түлхээд байж болохгүй биздээ.

Б.Жаргалсайхан /БНН-ын дарга/: Өндөр хөгжилтэй орнуудад намын гишүүнчлэл гэж байдаггүй. Намын удирдах байгууллага нь гишүүнчлэлтэй, доогууруа дэмжигчидтэй

байдаг юм. Манайхан болохоор баахан гишүүнч¬лэлтэй. Нам нь ялахаар л албан тушаал нэхэж, шантаажилдаг. Мэргэжлийн хүнийг албан тушаалд томилохоор энэ манай намын төлөө юу хийсэн юм гэж адалдаг. Ийм завхралаас болж төрийн бодлого алдагдсан юм шүү дээ. Намууд чадвар муутай хүмүүсийн цуглуулга болсон.

Гишүүн Ш.Сайхансамбуу /МАН/: Ер нь бол сонгуулийн ямар ч систем байлаа гээд бизнесийн бүлэглэлүүд орж ирэх л болно. Үүнийг таслан зогсооя гэвэл намын гишүүнчлэл гэсэн зүйлийг байхгүй болгох хэрэгтэй. Би УИХ-д суугаад хоёр жил боллоо. Энэ хугацаанд ажиглаад байхад гишүүнчлэл гэдэг зүйл хэрэггүй юм байна гэдгийг ойлгосон. Хамгийн ойрын жишээ гэхэд Ерөнхийлөгчийн сонгуулийг хар л даа. Монголчууд маань яаж намчирхаж хоёр талцав. Гэр бүлийн эхнэр нөхөр хоёр чиний нам ийм гээд хуваагдчихсан хэрэлдэж байх жишээтэй. Гэр бүлээр нь ингэж талцуулдаг явдал бидний хүсэх зүйл мөн үү. Гишүүнчлэл гээч юмыг байхгүй болгох хэрэгтэй. Дэмжигч гээд явж байна биз.

Гишүүн Ж.Сүхбаатар /МАН/: Улс төрийн намууд албадан маягийн гишүүнчлэлээсээ татгалзаж, үзэл бодол нэгтэй баг болж чадах хүмүүсээ нэгтгэж институт маягаар ажиллавал яасан юм бэ. Тэд дөрвөн жилийн хугацаанд Монгол орны хөгжлийн чиг хандлагад судалгаа хийж өөрчлөн сайжруулах төслөө зохиож ард иргэдэд сурталчилдаг, ард иргэд нь уг төсөл болон мөрийн хөтөлбөрөөс өөртөө аль таалагдсаныг нь сонгож саналаа өгдөг тогтолцоо нь хийрхлээс гарах нэгэн зам байж болох. Мэдээж ард түмний дийлэнхийн санал авч сонгогдсон төслөө уг нам өөрийн багаар хэрэгжүүлэх нь илүү бодитой байж болох юм. Сайн, илүү бодитой төсөл хийхийн тулд тухайн намын институт илүү чадварлаг боловсон хүчнүүдэд санал тавьж хамтран ажиллах боломж байгаа. Түүнчлэн улс төрд орохыг хүссэн хэн боловч тухайн намын институтэд санал тавьж, өөрийн хүч боломжоо харуулан хамтран ажиллаж бас болох шүү дээ. Харин жирийн иргэдийн хувьд аливаа хийрхлээс ангид, сэтгэл тайван, ажил амьдралдаа илүү анхаарлаа хандуулан, улс төрийн соёлд ч суралцах болно.

Гишүүн З.Алтай /бие даагч/: Энэ намын хатуу гишүүнчлэлийн асуудлыг болих ёстой. Хамаг дуучид нь хүртэл намын гишүүн болоод намын магтуу дуу дуулаад л явж байдаг. Хэдэн тамирчид нь хоёр хуваагдаад тэр намын тамирчин гээд явж байдаг. Иргэд нь хоёр хуваагдаад намын батлах өвөртлөөд явдаг. Манай нам гээд л “нам дагавал ам тосдоно” гэдэг заваан юм аль хэдийнэ хэрэгжээд эхэлчихсэн. Батлах өвөртлүүлье гэдэг шоу хийж байна. Энэ хамгийн буруу. Хуулиа хийх хэрэгтэй. Намын хатуу гишүүнчлэлийг больж, иргэд өөрсдийн үзэл бодлоороо л явах ёстой. Аль нэг программыг дэмждэг байх ёстой.

У.Хүрэлсүх /МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга/: Гишүүнчлэлээс татгалзах тухай асуудал улс төрийн намуудын дотор яригддаг. МАН ч гэсэн энэ асуудлыг хөндөж л байсан. Гэхдээ Монгол Улсын хуулиар улс төрийн намууд гишүүнтэй байх эрхтэй гээд заачихсан байгаа. Нам гишүүнчлэлгүй байх эсэх тухай асуудал улс төрийн намын тухай хуулианд өөрчлөлт орж байж шийдэгдэнэ. Одоогоор ярьж л байна. Монголд гишүүнчлэлээс татгалзсан нам одоогоор байхгүй. Гадаадад тийм байдаг ч манайд цаг үе нь хараахан биш байна гэсэн байна.

Мөн түүнчлэн 2010 оны УИХ-ын хаврын чуулганы нээлт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга нарын үгэнд Сонгуулийн хуулийг шинэчлэх, улс төрийн намуудыг гишүүнчлэлгүй болгох талаар дурдсан.

- НАМ ГИШҮҮНЧЛЭЛГҮЙ БАЙХ АСУУДЛААРХИ ОЛОН НИЙТ, ИРГЭДИЙН САНАЛ БОДОЛ

Ц.Шаравдорж /УИХ-ын Тамгын газрын ЕНБД/: Өнөөдөр дэлхийн улс төрийн намуудын практикаас үзвэл хатуу гишүүнчлэлтэй ч байна, гишүүнчлэлгүй ч байна. Ямар нь ч байлаа гэсэн тухайн орондоо улс төрийн сонгууль нь болоод л явж байгаа. Манайд бол өнөөг хүртэл хатуу гишүүнчлэлтэй явж ирсэн. Энэ практик

болохгүй байна гэсэн шүүмжлэл, үндэслэлүүд ч гарч байгаа. Би бол энэ дээр яг тэгэх ёстой гэж хэлмээргүй байна.

Э.Гэрэлт-Од /МУБИС-ийн багш/: Нам бол иргэдийн эрх чөлөө, улстөрийн оролцооны илэрхийлэл болж ардчиллыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй, улстөрийн хариуцлагыг төлөвшүүлдэг нийгмийн болон улстөрийн институт юм. Орчин үеийн намууд хатуу эсвэл сул гишүүнчлэлтэйгээс үл хамааран тухайн үнэт зүйлийг дэмжигч гишүүд болон сонгогчдод хэр хүрч, нээлттэй, хариуцлагатай байгаагаас хамааран сонгуульд ялалт байгуулдаг болсон.

Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвөөс “Улс төрийн намын тухай” хуулийн хэрэгжилтийн талаар Улаанбаатар хотын 200 гаруй иргэд, Өмнөговь аймгийн 1500 орчим иргэдийн дунд явуулсан санал асуулга явуулсан.

Судалдаанд оролцогчид “Монгол Улсын иргэн зөвхөн нэг намын харьяалалтай байна гэсэн хуулийн заалтыг та юу гэж үзэж байна” гэсэн асуултад оролцогчдын 91 хувь нь “буруу зохицуулалт”, “Улс төрийн намуудыг гишүүнчлэлгүй болгох асуудлыг та юу гэж үзэж байна” гэсэн асуултад оролцогчдын 88 хувь нь “дэмжиж байна”, “Улс төрийн намуудыг хязгаарлагдмал гишүүнчлэлтэй болгох асуудлыг та юу гэж үзэж байна” гэж асуултад81 хувь нь “Дэмжижж байна”, “Хуульд зааснаас бусад тохиолдолд намын гишүүн байх нь түүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл түүнд давуу байдал олгох үндэслэл болохгүй гэсэн хуулийн заалт амьдралд хэрхэн хэрэгжиж байна вэ?” гэсэн асуултад оролцогчдын 95 хувь нь “Хэрэгждэггүй” гэж хариулсан байна.

Энэхүү санал асуулгын дүнг нэгтгэхэд Монгол Улсын хувьд улс төрийн намууд гишүүнчлэлгүй байх хэрэгтэй, сонгууль болоход иргэд хамгийн сайн боловсруулсан мөрийн хөтөлбөрийг нь сонгон сонголтоо хийдэг, улс төрийн үйл ажиллагаанд зөвхөн дэмжигчээр оролцдог нөхцлийг бий болгох шаардлагатай гэж үзлээ.

## ДҮГНЭЛТ

1. Өнөөдөр дэлхийн улс төрийн намуудын практикаас үзвэл хатуу гишүүнчлэлтэй ч байна, гишүүнчлэлгүй ч байна. Ямар нь ч байлаа гэсэн тухайн орондоо улс төрийн сонгууль нь болоод л явж байгаа. Манайд бол өнөөг хүртэл хатуу гишүүнчлэлтэй явж ирсэн.

2. Улс төрийн нам хатуу гишүүнчлэлгүй тохиолдолд сонгуульд оролцоод санал авсан дэмжигчдийнхээ тоогоор “Манай нам Монголын нийт ард түмний төдөн хувийн дэмжлэгийг авлаа” гэсэн үр дүнгээр эрх барих хүчнээ тодорхойлж, засаглалаа тогтоож болно. Олон орон ийм загвараар явж байгаа. Энэ нь тухайн орныхоо тусгаар тогтнол, эв нэгдлийн баталгааг нэмэгдүүлдэг сайн талтай.

3. Нам байгуулж, бүртгүүлэхэд аль ч улс оронд нэг голлодог зүйл нь тухайн намын гишүүд болон дэмжигчдийн тоо байдаг. Ихэнх улс оронд үүнийг харгалзан бүртгэдэг. Барууны орнуудад намын гишүүнчлэл гэж бараг байдаггүй, зөвхөн дэмжигчид байдаг юм байна. Тиймээс тэнд намын гишүүдийн тоог харгалздаггүй. Харин яс гишүүнчлэлтэй орнуудын хувьд огт өөр. Жишээлбэл: Унгарт нам бүртгүүлэхэд гишүүнүүсгэн байгуулагчдын тоо 1000, Мексикт 65 мянгаар хэмжигддэг байна.

4. Анх 1990 онд улстөрийн нам төрийн ажлыг удирдах явдал дуусгавар болж байсан ч тухайн үедээ зарим нэг гол зарчмыг орхигдуулсан. Өөрөөр хэлбэл, төрийн албан дахь түшмэд, албан хаагчид зөвхон нийтийн сонирхолд захирагдаж ажиллах тухай асуудал жинхэнэ утгаараа хуульчлагдаагүй үлдсэн байсан.

5. Орон нутагт иргэдийн төлөөлөгчдийн хурал согуулиар байгуулагддаг хэрнээ намын

бүлэг байгуулдаг. Учир нь Иргэдийн төлөөлөгчдийн хуралд намын гишүүн иргэд нэр дэвшин сонгогддог. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам бус иргэдийг нэр дэвшин өрсөлддөг болгочихъё. Тэгвэл намын гар хөлийг иргэдийн төлөөллөөс хасч чадна. Ингэж байж л ИТХ жинхэнэ утгаараа иргэдийнх болж чадах билээ. ИТХ жинхэнэ иргэдийн төлөөллөөс бүрдэж чадвал орон нутгийн удирлага, засаг захиргааныхаа үйл ажлыг жинхэнэ утгаар нь хянаад байж болох юм. Иймээс орон нутаг дахь намуудын бүтцийг татан буулгая. Төрийн албан хаагчдыг намын гишүүнчлэлээс нь түдгэлзүүлсэнтэй адилаар орон нутгийн удирдлагыг ч гэсэн намын гишүүнчлэлээс чөлөөлөх хэрэгтэй гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

6. Монгол Улсад дахь намууд гишүүн элсүүлэх нь намын гол бодлого болж, намын гишүүн мөн болохыг баталсан батламж, үнэмлэхийг өнгөрсөн 20 жилийн турш цацжээ. Гэвч гишүүдээ хүндэтгэдэг, гишүүндээ чиглэсэн бодлого хэрэгжүүлдэг, тэдний улстөрийн боловсролд анхаардаг, гишүүдийн эрх, үүргийг хангадаг, хариуцлагатай намууд алга. Үндсэн хууль болон бусад хууль /намын тухай хууль/-ндаа улстөрийн намууд гишүүдийн эрх, эрх чөлөөг хэрхэн хангах, шийдвэр гаргах төвшинд хэрхэн оролцуулах, намууд ямар үүрэгтэй байх, мөн гишүүдийн үүрэг, хариуцлагыг огт тодорхойлоогүй байна. Энэ нь өнөөдрийн “гишүүдтэй атлаа гишүүнгүй намууд”-уудыг бий болгосон. Өөрөөр хэлбэл намтай холбогдох эрх зүйн орчинд буй нэг цоорхой бол оролцоот гишүүнчлэлийн бодлого бөгөөд хаа хаанаа гишүүдийн оролцоог дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлээгүй байна.

7. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд олон намууд үүсэж, улстөрийн тавцанд өрсөлдөж байгаа ч үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт нь бүхэлдээ төлөвшиж /ардчилагдаж/ чадаагүй л байна.

8. Орчин үед судлаачид улстөрийн намын дотоод ардчилал гэдэгт төрийн албанд буй өөрсдийн төлөөлөгчид болон лидерүүдийн үйл байдал, намын шийдвэрүүдийг удирдах, хянах гишүүдийн чадвар, хэр хэмжээ, тэдгээрийн идэвхитэй оролцоогоор тодорхойлогдоно гэж үзэж байна. Энэ бол намын ардчиллыг тодорхойлох ганц шалгуур бөгөөд иргэдийн улстөрийн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахын тулд гишүүд, дэмжигчдэд хүрч үйлчилж чадсан нам ардчилагдана, мөн сонгуульд ялалт байгуулна үздэг.

9. Улстөрийн намуудын засгийн эрх барих өрсөлдөөн нь улс болгонд хүний үндсэн эрхийг зөвшөөрөх, шударга, тэгш, өрсөлдөх боломжийг зорилготой. Сонгуулийн ардчилал нь нийгмийн салбаруудад, нэр дэвшигчийн бүлгүүдэд, төлөөлөх бодлого болон альтернатив улстөрийн намуудын хоорондын нээлттэй, шударга өрсөлдөөний зарчим дээр үндэслэдэг бөгөөд энэ нь санал хураах замаар шийдвэрлэгддэг. Хэрэв намын байгууллага үүнийг буруугаар ашиглавал эрх баригчидттай хариуцлага тооцох, сонирхлоо нэгтгэх, илэрхийлэх иргэдийн чадвар хязгаарлагддаг. Манай намуудын гишүүдэд ийм оролцоо байхгүй байна.

10. Манай улстөрийн намууд коммунист хэв шинжээс салаагүй байна. Угтаа нам бол гишүүнээр элсэх замаар иргэний эрх, чөлөөг эдлэх улстөрийн оролцооны нэг л суваг. Бид энэ сувгийг илүү нээлттэй болгох нь иргэд гишүүнээр элсдэг, элссэн гишүүд намын бүхий л шатны шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцдог, оролцоо нь намын санхүү, шийдвэр, үйл ажиллагаа, төрийн албанд томилогдсон болон сонгогдсон элит, лидерүүдийг хянах бүх боломжийг олгодог юм байна.

- УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ТУХАЙ ЗАРИМ ХЭРЭГЦЭЭТ ЦАХИМ ХУУДАС, ХАЙХ СЭДЭВ

1. http://en.wikipedia.org/wiki/Table_of_political_parties_in_Europe_by_pancontinental_organisation

2. http://en.wikipedia.org/wiki/Action_Party
3. http://www.extremism-and-democracy.com/ead/index.php?option=com_sobi2&letter=B&Itemid=53
4. http://en.wikipedia.org/wiki/Political_party
5. http://www.nationmaster.com/graph/gov_pol_par_and_lea_a_not-government-political-parties-leaders-note

- ХАЙХ СЭДЭВ

1. Politicial parties list without membership
2. List of countries without political party membership
3. Political parties statistics of the world
4. How many countries in the world with no political membership
5. Which countries are in the world with no political membership

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэлээрх эх сурвалж

1. Авлигын эсрэг сурвалж бичиг. Чөлөөт, шударга сонгууль. УБ., 2002, 18-р бүлэг.
2. Р.Бурмаа, Улс төрийн намууд, сонгууль ба илт тод байдал. Сайн засаглал, Олон улсын бага хурлын илтгэлүүд. УБ., 2002 он.
3. Монгол улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. Олон улсын бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Ред. Ж.Ядамсүрэн 2002 он
4. Монгол Улсын Хууль. Улс төрийн намын тухай хууль. 2005 он.
5. Монгол Улсын хууль. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. 2005 он.
6. С.Мөнхбат. “Улстөрийн намын санхүүжилт, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд” УТШН-ын Альтернатив сэтгүүл. УБ., 2003.
7. ННФ. 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын мониторинг тайлан. УБ., 2004 он.
8. ННФ, Сонгогчдын боловсрол төв. Улст өрийн намын санхүүжилтын мониторинг. УБ., 2007 он.
9. Сонгуулийн санхүүжилтын үнэлгээний судалгаа. Сонгогчдын боловсрол төв. 2007 он.
10. Улс төрийн хүрээн дэх мөнгөний урсгал, түүний ил тод байдал ба хяналтын тухай. Шинэ толь сэтгүүл. №47. УБ., 2004 он.
11. Шударга ёсны үзүүлэлтийн тайлан. Улс төрийн намуудын санхүүжилт. УБ., 2002 он.

Англи хэлээрх эх сурвалж

1. Ashton, M. 2006 “The Cartel Theory and the Funding of German Political Parties” draft version, PSA 2007.
2. “Campaign Finance” at http://en.wikipedia.org/wiki/Campaign_finance accessed on June 2, 2009.
3. Columbia-London Law Series: Party Funding and Campaign Financing in International Perspective ed. By Ewing K. and Issacharoff, S. Vol. 16 No. 9, September 2006,
4. Ferguson T. 1995 Golden Rule: The Investment Theory of Party Competition and the Logic of Money-Driven Political Systems , University of Chicago Press, Synopsis.
5. Hopkins, J. 2004. “The Problem with Party Finance: Theoretical Perspectives on the Funding of Party Politics” at LSE Research Online at website http://eprints.lse.ac.uk/archive/00000646 accessed on June 4, 2009.
6. Johnson, M. 2005 Political Parties and Democracy in Theoretical and Practical Perspectives. National Democratic Institute for International Affairs.
7. La Raja, R. 2009 “The Potential Effects of Public Funding on Political Parties” at http://campfin.polisci.wisc.edu/conf/LaRaja.pdf accessed on May 25, 2009.

8. Money In Politics: A Study of Party Financing Practices in 22 Countries 2005, ed. By Bryan, Sh. & Baer, D.
9. Pinto-Duschinsky, M. 2002, “Financing Politicsl: A Global View” in Journal of Democracy Vol. 13, Number 4, October 2002, pp. 69-86.
10. Pierre, J. Svasand, L. & Widfeldt, A. (2000) “State Subsidies to Political Parties: Confronting Rhetoric With Reality in West European Politics. Frank Cass & Company Ltd.
22. Pildat Background Paper: Selected Case Studies of Public Funding of Political Parties, 2005.
11. Poire, A. 2006. “Elements for a Theory of Political Finance” in Faculty Research Working Papers Series, John F. Kennedy School of Government, Harvard University.
12. Policy Brief, Centre for Governance and Development, 2005 March, Nairobi, Kenya
13. Roemer, J.E. 2006 “Party Competition Under Private and Public Financing: A Comparison of Institutions” in Advances in Theoretical Economics Vol. 6, Issue 1, 2006, pp.1-31. The Berkeley Electronic Press.
14. Sayers, A.M. 2004 “Election Campaign and Party Financing in Canada” in Democratic Audit of Australia, September 2004 at http://www.partyfinance.ca/publications/AustraliaDemAudit.pdf .
27. Shively, W.Ph. 2003, Power and Choice: An Introduction to Political Science, Eight edition,
15. Smith, B.A. Campaign Finance Regulation: Faulty Assumptions and Undemocratic Consequences Cato Policy Analysis no. 238, September, 1995.
16. The International IDEA Handbook series: Funding of Political Parties and Election Campaigns, 2003, ed. By Austin, R. and Tjernstrom, M.